

make the
right real



"Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг бодит болгоё!"

Инчеоны стратегийг Монгол Улсад хүлээн авах үндэсний уулзалт, семинар

MAKE THE RIGHT REAL WORKSHOP IN MONGOLIA

Government Building, Ulaanbaatar, Mongolia | 26 March 2014



MINISTRY OF POPULATION DEVELOPMENT
AND SOCIAL PROTECTION



GOVERNMENT OF
MONGOLIA



GOVERNMENT OF
MONGOLIA

MINISTRY OF HEALTH



MAKE THE RIGHT REAL WORKSHOP IN MONGOLIA

Organized by

Government of Mongolia
Ministry of Population Development and Social Protection of Mongolia
Ministry of Health of Mongolia



MINISTRY OF POPULATION DEVELOPMENT
AND SOCIAL PROTECTION



MINISTRY OF HEALTH



In Collaboration with

National Rehabilitation and Development Center of Mongolia
United Nations Economic and Social Commission for Asia and the Pacific (ESCAP)
World Health Organization (WHO)
Asia-Pacific Development Center on Disability (APCD)
The World Bank
National Human Rights Commission of Mongolia
CBR Asia-Pacific Network
Amici di Raoul Follereau (AIFO)
Japan International Cooperation Agency (JICA)



Government Building, Ulaanbaatar, Mongolia

26 March 2014

This report is available in a text format for persons with visual impairments and blind persons. Please contact info@apcdfoundation.org for further details.

TABLE OF CONTENTS



| | |
|--|-----|
| Summary Report | 4 |
| Appeal | 5 |
| Inaugural Speech by the Prime Minister of Mongolia | 7 |
| Memorial Message by the President of Mongolia | 11 |
| Memorial Message by the Parliament Chairman of Mongolia | 14 |
| Remarks by Minister, Ministry of Population Development and Social Protection of Mongolia | 18 |
| Remarks by United Nations Economic and Social Commission for Asia and the Pacific | 24 |
| Remarks by Minister, Ministry of Health of Mongolia | 31 |
| Remarks by Executive Director, Asia-Pacific Development Center on Disability | 37 |
| Remarks by National Human Rights Commission of Mongolia | 40 |
| Remarks by World Health Organization | 47 |
| Remarks by Mongolian National Federation of Disabled People's Organizations and Promoter for the Asian and Pacific Decade of Persons with Disabilities, 2013-2022 | 51 |
| Closing Remarks, United Association of People with Disabilities of Mongolia, Hero of Labor, State Honored Athlete of Mongolia, the Champion of Beijing 2008 Paralympic Games | 61 |
| Programme | 63 |
| Presentations | 65 |
| Media Coverage | 98 |
| Photo Gallery | 100 |

SUMMARY REPORT

The “Make the Right Real” Workshop was conducted in Ulaanbaatar, Mongolia, on 26 March 2014. The event was held by the Government of Mongolia through the Ministry of Population Development and Social Protection and the Ministry of Health in collaboration with the National Rehabilitation and Development Center of Mongolia, the United Nations Economic and Social Commission for Asia and the Pacific (ESCAP), the World Health Organization (WHO), the Asia-Pacific Development Center on Disability (APCD), the World Bank, the National Human Rights Commission of Mongolia, the Community-Based Rehabilitation Asia-Pacific Network, the Amici di Raoul Follereau (AIFO), and the Japan International Cooperation Agency (JICA).

Leading the event were Mongolian Prime Minister H.E. Mr. Altankhuyag Norov and H.E. Mr. Enkhbold Zandaakhuu, Chairman of Parliament of Mongolia, who delivered a special message. A message from the President of Mongolia, H.E. Mr. Elbegdorj Tsakhia was also shared in the opening. It was attended by more than 800 participants, including government officials, persons with disabilities and the business sector from the country’s rural communities.

One of the highlights of the event was the unveiling of not only the Mongolian translation of the Incheon Strategy to “Make the Right Real” but also of its other accessible formats such as sign language, audio and braille. These materials were handed over by the Minister of Population Development and Social Protection, H.E. Mr. Erdene Sodnomzundui to ESCAP’s Mr. Patrik Andersson, Social Integration Section Chief. The Government of Mongolia affirmed further collaboration with ESCAP, APCD and other partners to promote the movement on disability and development.



Opening Ceremony by Organizers

APPEAL

The Governments at the High-Level Inter-Governmental Meeting adopted the Ministerial Declaration on the Asian and Pacific Decade of Persons with Disabilities, 2013-2022, and the Incheon Strategy to “Make the Right Real” for Persons with Disabilities for Asia and the Pacific.

Today the Government of Mongolia launched the Incheon Strategy that puts us in a position for enhancing our responsibilities to improve quality of lives and social protection of persons with disabilities and to ensure the real implementation of their rights.

The Government of Mongolia approved the Action Plan and established the National Consultative Committee to implement the Incheon Strategy by its Resolution No. 80 dated 14 March 2014.

Given the high importance to effective implementation of the Incheon Strategy to “Make the Right Real”, we, the participants of the launching event, APPEAL to all level organizations, communities and citizens to work together towards implementing 10 goals and 27 targets with their 62 indicators.

We call for all level public and non-governmental organizations, mass media and private sector to join our efforts towards building a friendly environment for persons with disabilities in Mongolia. We believe the collaborative efforts shall make the rights of persons with disabilities REAL.

State Hall, Ulaanbaatar, Mongolia,
26 March 2014

Unanimously agreed by all participants
at “Make the Right Real” Workshop in Mongolia



Over 800 Participants Attending the Workshop

НҮБ-ын Ази, Номхон далайн бүсийн эдийн засаг, нийгмийн комиссоос Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2013-2022 оны 10 жилийн хөтөлбөрийн Сайд нарын Тунхаглал болон Ази, Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг бодит болгоё” Инчеоны Стратегийг тус тус баглан гаргасан.

Монгол Улсын Засгийн газар өнөөдөр Инчеоны стратеги баримт бичгийг хүлээн авч, хэрэгжүүлэх арга хэмжээг ёслол төгөлдөр зохион байгууллаа. Энэ цаг мөчөөс бид бүхний өмнө хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ амьдралын чанарыг сайжруулж, нийгмийн хамгааллыг бэхжүүлэн, эрхийг нь бодитойгоор хангахад чиглэсэн үүрэг хариуцлага улам ихээр оногдож байна.

Инчеоны стратеги баримт бичгийг хэрэгжүүлэх “Үйл ажиллагааны төлөвлөгөө” боловсруулж, “Үндэсний Зөвлөлдөх Хороо” байгуулан ажиллах тухай Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 80 дугаар тогтоол батлагдан гарсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг бодит болгоё” Инчеоны Стратегийг хүлээн авч, хэрэгжүүлэх ёслолын арга хэмжээнд оролцогч нийт төлөөлөгчдөөс энэхүү стратеги баримт бичгийг өндөр ач холбогдол, үр нөлөөтэй болохыг анхааран үзэж, тус баримт бичигт тусгагдсан 10 зорилго, 27 зорилт, 62 шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлэхийн төлөө бүх шатны байгууллагууд, иргэд-олон нийт Та бүхнийг хичээнгүйлэн ажиллахыг УРИАЛЖ байна.

Төрийн болон төрийн бус олон улсын байгууллага, хэвлэл мэдээллийн салбар, аж ахуйн нэгжүүдийг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ээлтэй нийгмийг цогцлоон бүтээх ажилд уриалан дуудаж, хамтран ажиллаж, түүчээ болохыг энэ ялдамд хусье. Та бидний хамтын зүтгэлээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх бодитойгоор хэрэгжинэ гэдэгт итгэлтэй байна.

Монгол Улс, Улаанбаатар хот, Төрийн ордон
2014 оны 03 дугаар 26-ны өдөр



Information Accessibility in the Workshop

INAUGURAL SPEECH



His Excellency Mr. Altankhuyag Norov Prime Minister of Mongolia

Your Excellency Speaker,
Distinguished Guests,
Ladies and Gentlemen,

I would like to extend my heartiest greetings to all of you who have gathered here from different parts of Mongolia to witness the launching ceremony of the Incheon Strategy “Make the Right Real” in Mongolia. On behalf of the Government of Mongolia, I would like to welcome all the distinguished international guests to our beautiful country from different parts of the world too.

Allow me to take this opportunity to wish every success in launching the Incheon Strategy to “Make the Right Real” for Persons with Disabilities in the Asia and Pacific region.

With the objective to ensure the social inclusion and equal participation of persons with disabilities in the Asia and Pacific region, today the Government of Mongolia is about to launch the Third Asian-Pacific Decade of Persons with Disabilities by the United Nations Economic and Social Committee for Asia and Pacific (ESCAP).

I would like to emphasize that ensuring the rights and empowerment of persons with disabilities, supporting their income and employment opportunities as well as providing secure livelihood conditions are inseparable components of the state policy of Mongolia.

The Reform Government of Mongolia formed in 2012 established the Ministry of Population Development and Social Protection with a priority not only to protect, but to develop the population and ensure equal opportunities for everyone. In this context, I have the pleasure to note that with the purpose to ensure the application of Article 33 of the United Nations Convention on the Rights of Persons with Disabilities (UN CRPD), a unit in charge of development of Persons with Disabilities has been newly established within the Ministry of Population Development and Social Protection of Mongolia.

Ladies and Gentlemen,

I would like to take this opportunity to commend the Government of Mongolia for the efforts put towards implementing the UN CRPD which was ratified by Mongolia in 2009.

Back in 2003, the Government of Mongolia adopted the Action Plan to implement the UN CRPD which has already become the legal framework for local authorities and governor's offices in implementing the Convention. While implementing the plan, 10 per cent of the Buyant-Ukhaa-1 apartment complex for 1,748 households has been allocated to the elderly citizens and persons with disabilities.

Today I have the pleasure to announce that the Government of Mongolia approved the Resolution No. 80 dated 14 March 2014 to establish the National Consultative Committee with the objective to ensure the implementation of the Incheon Strategy in Mongolia as outlined in the 5-year Action Plan of the UNESCAP's Asian and Pacific Decade of Persons with Disabilities, 2013-2022.

The National Consultative Committee will develop a 5-year Plan of Action with the involvement of a broad range of stakeholders from state and private organizations who support the persons with disabilities as well as of the persons with disabilities themselves and report to the ESCAP every three years.

As the goals set forth in the Incheon Strategy in regard to eliminating poverty, improving accessibility of public transportation and ICT, ensuring gender equality, protecting the rights of children with disabilities are in line with our policies on population development and poverty reduction, I hereby affirm Mongolia's commitment to cooperate with international stakeholders in achieving these goals.

The issues of persons with disabilities cannot be dealt and addressed merely by the social protection sector. I would like to emphasize the significance of multi-sectoral coordination in improving the quality of life of persons with disabilities. Moreover, the issues of persons with disabilities cannot be raised without the involvement of persons with disabilities themselves. By ensuring everyone's participation we can build a citizen-oriented society.

Lastly, I would like to highlight the importance of your commitment and dedication in incorporating the needs, interests and aspirations of persons with disabilities into the state policies and I strongly believe together we can largely contribute in improving the lives of persons with disabilities throughout Mongolia.

Let me now officially announce the opening of the launching ceremony.

Thank you.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг бодит болгоё” Инчеоны стратегийг Монгол Улсад хүлээн авч хэрэгжүүлэх ёслолын арга хэмжээнд хүрэлцэн ирсэн гадаад, дотоодын зочид, Монгол орны өнцөг бүрээс хуран цугларсан төлөөлөгчид Та бүхний энэ өдрийн амрыг айлтгая.

Ази, Номхон далайн бүсийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагааны тухай “Эрхийг бодит болгоё” Инчеоны стратегийг албан ёсоор хүлээн авч, олон талт салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр чуулах гэж буйд амжилт хүсэхийн хамт Нарлаг сайхан Монгол орныг зорин ирсэн гадаадын зочид, төлөөлөгчид Та бүхэнд Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлбэ.

Монгол Улс Ази, Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэмшүүлэх, саадыг арилгах, оролцоог тэгш хангах зорилгоор НҮБ-ын Ази, Номхон далайн нийгэм, эдийн засгийн хорооноос зарлаж буй гурав дахь Арван жилийг албан ёсоор хүлээн авах гэж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хүндэтгэж, тэдний хөгжлийг дэмжих, оролцоог хангах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогыг нь нэмэгдүүлэх, амьжиргааны түвшинг баталгаажуулах асуудал нь Монгол Улсын төрийн бодлогын салшгүй чухал хэсэг юм.

2009 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай НҮБ-ын Конвенцийг соёрхон баталснаас хойш нэлээдгүй хугацаа өнгөрчээ.

Шинэчлэлийн Засгийн газрын бүтцэд өөрчлөлт хийж, хүн амыг зөвхөн хамгаалах биш хөгжүүлэх, бүгдэд тэгш боломж олгох үндсэн чиг үүрэгтэйгээр НХХЯ нэртэй байсан яамыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам болгосноо дуулгахад таатай байна. Конвенцийн 33-р зүйлийг хэрэгжүүлж тус яаманд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан Төрийн анхдагч нэгжийг шинээр байгуулсан.

2013 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай НҮБ-ын Конвенцийг хэрэгжүүлэх Үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж орон нутгийн Засаг дарга нар орон нутагтаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ төлөө үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэх боломжтой болсон нь Шинэчлэлийн Засгийн Газраас хэрэгжүүлсэн бодитой ажил болсныг тэмдэглэмээр байна.

“Буянт - Ухаа 1” цогцолборын 1748 айлын орон сууцны 10 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудад олгохоор шийдвэрлэсэн.

НҮБ-ын Ази, Номхон далайн бүсийн эдийн засаг, нийгмийн комиссоос баталсан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Эрхийг бодит болгоё” Инчеоны стратегийн 2013-2022 оны 10 жилийн хөтөлбөрийн эхний 5 жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасны дагуу Монгол Улсын Засгийн газар энэхүү стратегийг хүлээн авч, хэрэгжүүлэх “Үндэсний Зөвлөлдөх Хороо”-г байгуулах шийдвэр бүхий Засгийн газрын 2014 оны 03 сарын 14-ний хуралдаанаар 80 дугаар тогтоол батлагдсаныг дуулгахад таатай байна.

Засгийн газраас “Үндэсний Зөвлөлдөх Хороо”-г байгуулснаар төрийн бүх шатны байгууллагууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэднийг дэмжих байгууллагууд, хувийн хэвшил зэрэг олон талт салбарын үйл ажиллагааг хамруулсан, тэдгээрийг татан оролцуулсан Инчеоны Стратегийн зорилго, зорилтод хүрэх “Үйл ажиллагааны төлөвлөгөө”-г 5 жил тутамд боловсруулан хэрэгжүүлж, хэрэгжилтийн явцыг 3 жил тутамд Ази, Номхон далайн бүсийн нийгэм, эдийн засгийн хороонд тайлагнаж байх юм.

Инcheon-ын стратегийн үндсэн зорилгууд болох ажлын байрыг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах, мэдээлэл, харилцаа холбоо, нийтийн тээврийн хүртээмжийг сайжруулах, жендерийн эрх тэгш байдал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудал зэрэг нь манай улсын хүн амаа хөгжүүлэх, ядуурлыг бууруулах бодлогын нэг учир бид Ази, Номхон далайн бүсийн нийгэм, эдийн засгийн хороо болон бүсийн улс орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд хүчин чармайлт гаргаж, хамтран ажиллах болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудал нь дан ганц нийгмийн халамж, хамгааллын салбарын асуудал биш бөгөөд тэдний амьдралын нөхцөлийг дээшлүүлж, эрхийг бодитойгоор хангахад салбар бүрийн хамтын ажиллагаа нэн чухал болохыг онцлон тэмдэглэе. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай ярихад тэдэнгүйгээр ямар ч асуудлыг шийдэхгүй. Аливаа асуудлыг иргэний оролцоотой шийдвэрлэж байж бид иргэн төвтэй нийгмийг байгуулж чадна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашиг, хэрэгцээ сонирхол, хүсэл тэмүүлэлд үндэслэн Төр, засгаас дэвшүүлж буй шинэчлэлийн бодлогыг гардан хэрэгжүүлэх хөгжлийн эзэд Та бүхэн асуудалд чин сэтгэлээсээ хандаж, үүрэг хариуцлагаа ухамсарлаж, Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сайн сайхны төлөөх үйлсэд томоохон хувь нэмэр оруулна гэдэгт итгэж буйгаа илэрхийлье.

Ёслолын арга хэмжээ нээснийг мэдэгдэе.

Төлөөлөгчдөд амжилт хүсье.

MEMORIAL MESSAGE



His Excellency Mr. Elbegdorj Tsakhiagiin President of Mongolia

Ladies and Gentlemen,
Distinguished Guests,

I would like to extend my warmest greetings to our distinguished guests who arrived here to be a part of the Memorable Event dedicated towards launching Incheon Strategy to "Make the Right Real" for Persons with Disabilities in Mongolia proclaimed from the United Nations Regional Economic and Social Commission for Asia and the Pacific (ESCAP).

As we are all aware the World Program of Action Concerning Disabled Persons proclaimed the First Asian and the Pacific Decade of Disabled Persons, 1993-2002, to support people with disabilities, the Second Asian and Pacific Decade of Disabled Persons, 2003-2012, to track progress towards improving the quality of life, and fulfillment of the rights of persons with disabilities, and approved the Biwako Millennium Framework for Action: towards an inclusive, barrier-free and rights-based society for Persons with Disabilities in Asia and the Pacific. In line with these internationally agreed documents. Mongolia has given priority in our national development agenda and has been implementing programs and action plans designed to ensure the development and promotion of the living conditions of persons with disabilities.

I am pleased to recall the opportunity to participate at the High-Level Meeting of the United Nations General Assembly on Disability and Development with focus on international and regional cooperation and partnerships. I consider it to be praiseworthy that the rights, development, and participation of persons with disabilities are discussed at the global level. Allow me to reaffirm the significant importance of launching and implementing Incheon Strategy to "Make the Right Real" for Persons with Disabilities in Mongolia.

We align ourselves to the mission to create a favorable society for persons with disabilities, so that they can enjoy their rights, and be the creators and discoverers of their own faith. I can fully assure you that the Government of Mongolia is fully committed in the implementation of various actions and programs to support the development of persons with disabilities. I would like to inform you about the Mongolian President's mandate to give lifetime incentives on a monthly basis for athletes who demonstrated their abilities and won medals from world championships such as the Olympics and Paralympics. It is my honor to

mention that the mandate was a great incentive and now we have a gold medalist from the World Paralympics Championship Games. It is my pleasure to note that persons with visual impairments can vote in the Presidential Elections, which is an indicator of our progress towards the development of persons with disabilities.

We, Mongolians, have a great custom of supporting and helping those in need, in particular the elderly, children, and persons with disabilities. Therefore, we need to assign ourselves to the mission to provide the rights, promote the participation at all levels of society, and create a favorable environment to ensure the development and protection of persons with disabilities.

I believe the good deeds would bring their fruits once persons with disabilities are better informed and their participation at all levels of society is promoted. I believe we have a common goal at the global arena.

Lastly, I would like to reaffirm my commitment to strengthen our cooperation at all levels to build a favorable environment, and we gathered here to accelerate our joint efforts for the Memorable Event of launching the Incheon Strategy. I would like to express every success in achieving your goals.

Thank you for your attention.

Эрхэмсэг хатагтай, ноёд оо,

Нэгдсэн Үндэстний байгууллагын Ази, Номхон далайн бүсийн эдийн засаг, нийгмийн комиссоос баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг нь бодит болгоё” Инчеоны стратегийг Монгол Улсад хүлээн авч хэрэгжүүлэх ёслолын арга хэмжээ, уулзалтад хүрэлцэн ирсэн дотоод, гадаадын зочид төлөөлөгчид Та бүхний түмэн амгаланг айлтгаж чин сэтгэлийн халуун мэндчилгээ дэвшүүлье.

Дэлхийн хамтын нийгэмлэгээс 1993-2002 оныг “Ази, Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих 10 жил”, 2003-2012 оныг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүрэн оролцоог хангасан, ая тухтай, хүний эрхэд тулгуурласан нийгмийг цогцлон бүрдүүлэх жилүүд болгож үйл ажиллагааны “Бивакогийн мянганы хөтөлбөр”-ийг тус тус баталсан билээ. Монгол Улс дээрх хөтөлбөрүүдэд тулгуурлан өөрийн орны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих, аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчид “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоотой хөгжлийн асуудлаарх олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагаа түншлэл” сэдэвт НҮБ-ын Ерөнхий Ассамблейн өндөр түвшний хэлэлцүүлэгт оролцож үг хэлэх завшаан тохиосон билээ. Хүмүүний хөгжлийн бэрхшээлийг онцгой асуудал хэмээн үзэж, тэдгээр иргэдийн эрх ашиг, хөгжил, оролцооны асуудлыг дэлхий нийтээрээ анхааран хэлэлцдэг болж байгаа нь туйлын сайшаалтай хэрэг.

НҮБ-ын Ази, Номхон далайн бүсийн эдийн засаг, нийгмийн комиссоос баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг нь бодит болгоё” Инчеоны стратегийг Монгол Улсад ёслол төгөлдөр хүлээн авч, хэрэгжүүлэх арга хэмжээг хэлэлцэж байгаа нь чухал ач холбогдолтой үйл явдал болж байна.

Монгол Улс чухамхүү хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй нийгмийг бий болгох, тэдгээр иргэд бусдын адил хөгжлийн үр шимийг хүртдэг төдийгүй түүнийг бүтээгч, туурвигч байх орчин нөхцөлийг бүрдүүлэхийг зорьж байна. Манай Засгийн газраас энэ талаар олон ажил хийж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гарган олимпийн наадам, паралимп болон олимпийн наадмын төрөлд багтдаг сонирхогчдын спортын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс медаль хүртсэн иргэнд насан туршид нь сар бүр олгох урамшууллыг бий болгосон бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс дэлхийн паралимпын наадмын алтан медаль хүртэж элэг нэгтнүүдээ баярлуулсан сайхан үйл явдал тохиосон билээ. Өнгөрсөн онд манай оронд болсон Ерөнхийлөгчийн сонгуулиар хараагүй иргэд саналаа өгөх боломжоор хангагдсаныг дурдахад таатай байна.

Монголчууд бид өндөр настан, хүүхэд багачууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ер нь ядарч яваа нэгэндээ тусалж, энэрч хайрлаж ирсэн сайхан уламжлалтай ард түмэн. Тиймээс бид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ эрх ашиг, хөгжил, хамгааллын асуудлыг авч үзэхдээ нэн тэргүүнд тэдэнд ээлтэй, таатай орчныг бүх түвшинд бий болгохыг чухалчлах хэрэгтэй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь мэдээлэлтэй болж, оролцоо нь илүү өргөжих аваас сайн үйлс улам дэлгэрнэ. Дэлхийн хамтын нийгэмлэг энэ асуудал дээр нэгдмэл нэг санаатай байгаа нь мэдээж. Бид ижил зорилготой хүмүүс. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сайн сайхан байдлыг цогцлоон бүтээхийн төлөөх хамтын ажиллагааг бүх талаар идэвхжүүлж, хүчин чармайлтаа нэмэгдүүлэхээр хуран цуглаад буй Та бүхний ажил үйлс өөдрөг, зорилго бүтэмжтэй байх болтугай.

Та бүхэндээ амжилт хүсье.

MEMORIAL MESSAGE



His Excellency Mr. Enkhbold Zandaakhuu Chairman of Parliament of Mongolia

I would like to extend my warmest greetings to our distinguished guests who arrived here to be a part of the memorable event dedicated towards launching Incheon Strategy “Make the Right Real” for Persons with Disabilities in Mongolia.

The matter of persons with disabilities has always been a challenge throughout the history of mankind. We align ourselves to the mission to eliminate any discrimination and provide equal participation of persons with disabilities in all aspects of the society by creating a favorable environment and enabling the conditions to meet their specific needs. The first Law on Social Protection of Disabled People was adopted in 1995 by the Parliament of Mongolia, that has created the legal framework to address the social protection challenges, assistance, and benefits of persons with disabilities. Later on the law was amended and adopted to the Law on Social Protection of People with Disabilities in 2005.

As a former Chairman of the Security and Foreign Policy Standing Committee of the Parliament, I have accomplished to submit the United Nations Convention along with the Optional Protocol on Persons with Disabilities to the Parliament of Mongolia, which ratified them on 12 October 2008. The ratification of the above documents provided the opportunity and guarantee for persons with disabilities to enjoy equal rights, and participate in social relations.

The Parliamentary Session of February 2013 approved the Law on the Amendment to the Law on Social Protection of the Persons with Disabilities that resulted in making amendments to the respective Laws on Health, Education, Elementary Education, Preliminary Education, Social Welfare, and so on. The above changes provided persons with disabilities with full rights to receive health care and social welfare services, and provided access to education. I believe that we have commenced important activities to promote the development of Mongolian persons with disabilities in the spirit of the Convention on the Rights of Persons with Disabilities.

I am pleased to inform you that we fully dedicate ourselves to confirm that the legislations to be approved by the Parliament of Mongolia are in accordance with the United Nations Convention on the Rights of Persons with Disabilities and accelerate our joint efforts to ensure that laws and regulations are practical and feasible.

I believe that the Incheon Strategy to “Make the Right Real” proclaimed within the framework of the Third Asian Pacific Decade is a document of high importance to make progress towards promoting disability-inclusive social development.

I am pleased to highlight the importance of the second goal of the Incheon Strategy to promote participation in political processes and decision-making as an encouragement and cornerstone towards implementing the rights of persons with disabilities. To be able to exercise the right to be elected and to participate in the process of voting is the motivation and mainstream to achieve the goal. I believe that within the framework of the 10-year strategy, we can achieve the broader participation of persons with disabilities at all levels of the society.

Allow me to reaffirm that together we can accomplish the implementation of the strategic goals and objectives of the Incheon Strategy to support the rights of persons with disabilities, as well as to improve the legal environment to promote inclusive participation and provide the equal rights of persons with disabilities.

Lastly, I would like to wish a fruitful outcome and every success to the event and workshops, and express my personal wish for health, success for all the people with disabilities in Mongolia.

Thank you for your attention.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Эрхийг бодит болгоё” Инчеоны стратегийг Монгол Улсад хүлээн авах үндэсний уулзалт, семинарт хүрэлцэн ирсэн гадаад, дотоодын хүндэт зочид, төлөөлөгчид Та бүхэнд чин сэтгэлийн халуун мэндчилгээг дэвшүүлэе.

Хүн төрөлхтний түүхэн хөгжлийн бүх үед нийгмийн давхарга, газар нутаг, улс үндэстэн алинд ч ялгаагүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал тухайн нийгэмд тулгамдсан асуудал байсаар ирсэн.

Манай улс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд аливаа ялгаваргүйгээр тэгш оролцуулах нөхцөлийг бүрдүүлэх, тэдний өвөрмөц хэрэгцээнд түшиглэсэн нийгмийн хамгааллын тогтолцоог бий болгоход байнга анхаарч ирсэн. Улсын Их Хурлаас 1995 онд анх удаа “Тахир дутуу иргэдийн нийгмийн хамгааллын тухай” хуулийг баталж, 2005 онд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай” хууль болгон шинэчлэн найруулж баталсан. Ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх нийгмийн хамгааллын арга хэмжээ, тэдэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлтийн асуудлыг шийдвэрлэх эрх зүйн орчныг бүрдсэн.

Миний бие УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар ажиллаж байхдаа 2008 оны 12 дугаар сард “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай” НҮБ-ын конвенцийг нэмэлт протоколын хамт Монгол Улсын Их Хуралд оруулж, соёрхон батлуулсан. НҮБ-ын конвенцийг нэмэлт протоколын хамт баталснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэд эрхээ бусдын адил эдэлж, нийгмийн харилцаанд орох боломж баталгаажсан юм.

Энэ удаагийн Улсын Их Хурал 2013 оны 2 дугаар сард “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийг баталж, үүний дагуу “Эрүүл мэндийн тухай”, “Боловсролын тухай”, “Бага, дунд боловсролын тухай”, “Сургуулийн өмнөх боловсролын тухай”, “Нийгмийн халамжийн тухай” хуулиудад зохих нэмэлт, өөрчлөлт орууллаа. Энэ өөрчлөлтөөр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах, сурч боловсрох, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах эрхийг бүрэн хангах боломжтой болж байна. Энэ нь Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай конвенцийн үзэл санаанд нийцүүлэн томоохон ажил хийсэн гэсэн үг юм.

Бид цаашдаа УИХ-аар хэлэлцэн батлагдаж буй хууль тогтоомжийг “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай” НҮБ-ын конвенцийн үзэл санаа, зарчимд нийцүүлэн гаргаж, батлагдсан хууль, тогтоомж амьдралд ойр, хэрэгжих боломжтой байх бүхий л нөхцөл бололцоог бүрдүүлж ажиллана.

Ази, Номхон далайн бүс нутгаас зарласан 3 дахь 10 жилийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Эрхийг бодит болгоё” Инчеоны стратеги нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх нийгмийн үйлчилгээнд дэвшил гаргах чухал баримт бичиг болсон гэж үзэж байна.

Инчеоны стратегийн Улс төрийн болон шийдвэр гаргах үйл явцад оролцоог дэмжих 2 дугаар зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хэрэгжүүлэх тулгын чулуу нь юм. Сонгох, сонгогдох эрхээ эдлэх нь энэхүү зорилгод хүрэх маш чухал зүйл. Энэхүү 10 жилийн стратегийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд улс төрийн болон шийдвэр гаргах бүх түвшинд илүү өргөн хүрээтэй оролцох боломж нэмэгдэнэ.

Бид Ази, Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих Инчеоны стратегийг дэмжиж, эдгээр зорилго, зорилтуудыг 2013-2022 онд хэрэгжүүлэх, улмаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх хууль эрх зүйн орчинг улам боловсронгуй болгож, тэднийг бусдын адил нийгэмд бие даан амьдрах, тэгш оролцох оролцоог шинэ шатанд гаргахын төлөө ажиллах болно.

Уулзалт, семинарын үйл ажиллагаанд амжилт хүсч, Монголын хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэддээ эрүүл энх, ажлын амжилт, хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

REMARKS



MINISTRY OF POPULATION DEVELOPMENT
AND SOCIAL PROTECTION

Mr. Erdene Sodnomzundui Minister, Ministry of Population Development and Social Protection of Mongolia

Your Excellency Speaker,
Your Excellency the Prime Minister,
Members of Parliament,
Distinguished Guests,
Ladies and Gentlemen,

Allow me to extend my warmest greetings to the guests representing different regions of Mongolia and our international organizations that do provide extensive role and contribution to promoting activities towards persons with disabilities. It is my pleasure to welcome you all to the launching ceremony of the Incheon Strategy to “Make the Right Real” for Persons with Disabilities, 2013-2022, in Mongolia.

As we are all aware the United Nations adopted the Asian and Pacific Decade of Persons with Disabilities 1993-2002 and the Biwako Millennium Framework for Action towards an inclusive, barrier-free and rights-based society for persons with disabilities in Asia and the Pacific. As for Mongolia, the Government has been developing and implementing the National Program to support the livelihood of persons with disabilities according to the UN-adopted recommendations and documents.

Taking this opportunity, I would like to highlight that the establishment of an independent unit designed to identify and develop policies targeted at persons with disabilities within the Ministry of Population Development and Social Protection was a timely and significant action taken by the newly formed Government of Mongolia towards implementing Article 33 of the United Nations Convention on the Rights of Persons with Disabilities.

In the past the issues of persons with disabilities have been limited to social protection and employment, while promotion of their rights, ensuring social inclusion and development of persons with disabilities are presently high in the state development agenda and policies.

Among the 4.1% of the total population of Mongolia (108,000 people) 34% are people with birth disability while 66% are people with acquired disability. If you divide the numbers according to the types of disability, 29% have physical disability, 19% have mental disability, 15% are visually impaired, 12% have hearing impairments and 6% have speech impairments. While 22% of persons with disabilities aged above 10 years old are uneducated, the remaining

78% have some level of education. Compared to the total population of the nation the level of education of persons with disabilities is lower by 14.5 points. As for employment status, only 20% of all persons with disabilities more than 15 years old are employed while the remaining 80% are unemployed.

Another challenging issue is that persons with disabilities are not provided with equal accessibility to information, transportation and infrastructure. Limited availability of accessible transportation is a constant challenge that hinders opportunities for persons with disabilities to get employed and receive medical assistance.

Therefore, I would like to emphasize that ensuring the rights and development of persons with disabilities by increasing their participation is not the mandate of our Ministry only, but can only be achieved through stronger inter-sectorial coordination and cooperation.

Nevertheless, I would like to bring to your attention some major activities we have undertaken with regard to improving the legal environment and ensuring the rights, integration and development of persons with disabilities as follow:

1. Issues related to persons with disabilities including community-based inclusive development, education, employment and empowerment were incorporated into a new draft National Population Development Policy of Mongolia.
2. At the moment the Law on Social Protection of Persons with Disabilities is being drafted in line with the concepts and principles of the UN CRPD with the aim to set up a legal framework to ensure the rights and development of persons with disabilities.
3. We are working towards establishing Health, Education and Social Protection Joint Commission in charge of early detection, diagnosis and development of children with disabilities.
4. We have already commenced the establishment of a child development center which provides community-based rehabilitation and development services in 21 provinces and 9 districts.
5. Scope of services provided by the National Rehabilitation and Development Center to persons with disabilities is extended to diverse rehabilitation services using new prosthesis and orthopedic technologies.
6. With the purpose to develop disability studies in Mongolia, we accelerated activities to conduct research and to organize events on disability-related theoretical and practical issues.

By implementing the Incheon Strategy, the Government of Mongolia expects the following outcomes:

1. Increase participation of children and young persons with disabilities in vocational training, increase job opportunities for persons with disabilities, enhance work and employment prospects, and reduce poverty through income support;

2. Ensure that persons with disabilities are represented in working groups that formulate, implement and monitor the state policies and guidelines, promote participation of persons with disabilities in political processes and in decision-making;
3. Enhance access to the physical environment, public transportation, knowledge, information and communication;
4. Strengthen social protection of persons with disabilities through enhanced services and programs, including personal assistance and peer counseling, that support persons with disabilities' independent living in the community;
5. Enhance measures for early detection of children with disabilities within the family, ensure access to quality primary and secondary education on an equitable basis with others in the communities;
6. Increase social participation of girls and women with disabilities and protect them from all forms of violence and abuse;
7. Develop disability-inclusive disaster risk planning and strengthen emergency preparedness;
8. Establish accurate database of persons with disabilities;
9. Ensure the rights of persons with disabilities outlined in the UN CRPD and improve their quality of life;
10. Strengthen multi-sectoral cooperation concerning disability issues and intensify the activities of the National Consultative Committee on Disability.

Lastly, I would like to highly encourage the engagement of all Government level bodies, organizations for persons with disabilities and the persons with disabilities themselves to put together your efforts in successfully implementing the Incheon Strategy.

I thank you.

Эрхэм хүндэт Монгол Улсын Их Хурлын даргаа
Эрхэм хүндэт Монгол Улсын Ерөнхий сайдаа
Улсын их хурлын эрхэм гишүүдээ
Хүндэт зочид, төлөөлөгчидөө
Хүндэт Хатагтай, ноёдоо

Та бүхэнд хаврын энэ сайхан өдрийн мэндийг хүргэхийн ялдамд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг бодит болгоё” 2013 - 2022 оны Инчеоны стратегийг Монгол улс хүлээн авч, хэрэгжүүлэх үндэсний уулзалт, семинарт оролцохоор эх орны өнцөг булан бүрээс хүрэлцэн ирсэн төлөөлөгчид болон Монгол улсын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөө сэтгэл зүрхээ зориулан туслан дэмжиж, хамтран ажиллаж байдаг олон улсын байгууллагын хүндэт зочид та бүхэнд чин сэтгэлийн халуун мэндчилгээ дэвшүүлье.

Нэгдсэн Үндэсний Байгууллагаас 1993-2002 оныг “Ази, Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих 10 жил”, 2003-2012 оныг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүрэн оролцоог хангасан, ая тухтай, хүний эрхэд тулгуурласан нийгмийг цогцлон бүрдүүлэх талаарх үйл ажиллагааны “Бивакогийн Мянганы Хөтөлбөр”-ийг баталсан. Монгол Улс дээрх олон улсын байгууллагын зөвлөмж, хөтөлбөрт үндэслэн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих, аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөрийг боловсруулан, хэрэгжүүлж ирсэн.

Шинэчилсэн Засгийн газар НҮБ –ын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн 33-р зүйлийг хэрэгжүүлж ХАХНХЯаманд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого чиглэлийг тодорхойлох бие даасан хэлтсийг байгуулсан нь чухал ач холбогдолтой арга хэмжээ болсоныг онцлон тэмдэглэхэд таатай байна.

Өмнө нь төр засгийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар баримтлах бодлого нь нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг нэгтгэн авч үздэг байсан бол одоо хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ эрх, оролцоо, хөгжлийн асуудлуудыг нэн тэргүүнд авч үзэх бодлогыг баримтлан ажиллаж байна.

Монгол Улсын нийт хүн амын 4,1% буюу 108 мянга гаруй хүн хөгжлийн бэрхшээлтэй байна. Үүнээс 34% нь төрөлхийн, 66% нь олдмол юм.

Хөгжлийн бэрхшээлийг хэлбэрээр авч үзвэл: 29% нь хөдөлгөөний бэрхшээлтэй, 19% нь сэтгэцийн, 15% нь харааны бэрхшээлтэй, 12% нь сонсголын бэрхшээлтэй, 6% нь ярианы бэрхшээлтэй байна. 10 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 22% нь боловсролгүй, 78% нь ямар нэгэн боловсролтой байна. Энэ нь жирийн хүн амтай харьцуулахад боловсролын түвшин нь 14.5 пунктээр доогуур байна гэсэн үг юм.

15, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 20% нь ажил эрхэлдэг, 80% нь ажилгүй байна.

Ихэнх барилга байгууламж, тээврийн тогтолцоо болон мэдээлэл бүх хүнд ижил хүртээмжтэй биш байна. Тээврийн хэрэгслийн хүртээмж дутмаг байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүн ажил хайх, эсвэл эрүүл мэндийн тусламж дэмжлэг саадгүй авахад үргэлж бэрхшээл учруулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангаж, оролцоог нэмэгдүүлж хөгжүүлэх нь зөвхөн манай яамны асуудал биш харин олон талын салбарын хамтын ажиллагаанд хэрэгжих учиртай.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хөгжил, эрх, оролцоог хангах чиглэлээр хэрэгжүүлж буй томоохон ажлуудыг дурьдвал:

1. Монгол улсын төрөөс баримтлах “ Хүн амын хөгжлийн цогц бодлого” -д хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамт олонд нь түшиглэн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгэмшүүлэх, эрх мэдэлжүүлэх чиглэлээр хамруулан хөгжүүлэх зарчмыг тусгаж өгсөн.
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийг конвенцийн үзэл баримтлалтай нийцүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, хөгжлийг хангасан хуулийг боловсруулаж байна.
3. Хөгжлийг бэрхшээлтэй хүүхдийг эрт илрүүлж тодорхойлох, хөгжүүлэх, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын хамтарсан комиссыг байгуулан ажиллаж байна.
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамт олны дунд сэргээн засаж, хөгжүүлэх, Хүүхэд хөгжлийн төвүүдийг 21 аймаг, 9 дүүрэгт үе шаттайгаар байгуулах ажил хэрэгжиж эхэлсэн.
5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд цогц сэргээн засах тусламж, үйлчилгээг үндэсний хэмжээнд үзүүлдэг ХАХНХЯ-ны харьяа Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, шинэ техник, технологи бүхий эрүүл мэндийн сэргээн засах тусламж, үйлчилгээ, сэргээн засах туслах хэрэгсэл, хиймэл эрхтэн үйлдвэрлэх, эрт үеийн оношлогоо, үнэлгээний цогц үйлчилгээг үзүүлдэг төв болгон хөгжүүлж байна.
6. “Хөгжлийн бэрхшээл судлал салбар шинжлэх ухааныг хөгжүүлэх” зорилгоор Эрдэм шинжилгээний онол практикийн хурлуудыг тогтмол зохион байгуулж, судалгаа шинжилгээний ажлуудыг эрчимжүүлж байна.

Цаашид Инчеоны стратегийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрэхийг зорьж байна.

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудыг мэргэжлийн сургалтанд хамруулан сургаж, хүртээмжтэй ажлын байрыг бий болгож, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлж, ядуурлын түвшинг бууруулна.
2. Төрийн бодлого, дүрэм, журам боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийг оролцуулж, улмаар улс төрийн болон шийдвэр гаргах түвшинд тэдний оролцоог дэмжинэ.
3. Олон нийтийн газарт зорчих хүрээлэн буй орчны саадыг арилгах, бүх төрлийн нийтийн тээврийг ашиглах нөхцлийг бүрдүүлэх, мэдээлэл авах, дамжуулах, хүргэх харилцааны хүртээмжийг сайжруулна.
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гэр бүл хамт олон дундаа бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх, хувийн туслах болон зөвлөгөө өгөх үйлчилгээ, хөтөлбөрийг дэмжиж нийгмийн хамгааллыг бэхжүүлнэ.
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг гэр бүлийн түвшинд эрт илрүүлж, цэцэрлэг, сургуульд, хамт олны дунд хамруулан хөгжүүлж, боловсрол олгохыг нэмэгдүүлнэ.

6. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн нийгэмд оролцох оролцоо нэмэгдэнэ. Бүх төрлийн хүчирхийлэл, доромжлоос хамгаалагдана.

7. Гамшигийн эрсдлийн төлөвлөгөө боловсрогдож, яаралтай аврах ажиллагаа сайжирна.

8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэдсэн мэдээллийн сан бий болно.

9. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцид заасан эрхүүд бодитоор хангагдаж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралын чанар сайжирна.

10. Олон талын салбарын хамтын үйл ажиллагаа сайжирч үндэсний түвшинд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангаж ажиллах Үндэсний Зөвлөлдөх хорооны үйл ажиллагааг идэвхжинэ.

Дээрх үр дүнд хүрэхийн тулд Засгийн газрын бүх шатны байгууллагууд түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдгээрийг дэмжих байгууллагуудыг Инcheon Стратегийг хэрэгжүүлэх чиглэлээр хичээл зүтгэл гарган хамтран ажиллахыг уриалж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

REMARKS



Mr. Patrik Andersson
Chief, Social Integration Section, Social Development,
United Nations Economic and Social Commission
for Asia and the Pacific

Your Excellency, Mr. Altankhuyag Norovyn, Prime Minister of the Government of Mongolia,
Your Excellency, Mr. Erdene Sodnomzundui, Minister for Population Development and
Social Protection,

Your Excellency, Dr. Udval Natsag, Minister for Health,
ESCAP Promoter for the Asian and Pacific Decade of Persons with Disabilities,
Mr. Oyunbaatar Tseden,

Mr. Byambadorj Jamsran, Chief Commissioner of the National Human Rights Commission
of Mongolia,

Dr. Soe Nyunt-U, World Health Organization Representative in Mongolia,

Mr. Akiie Ninomiya, Executive Director of Asia-Pacific Development Center on Disability,
Distinguished Guests,

Dear Friends and Colleagues in the disability community,
Ladies and Gentlemen,

It is indeed a great honor for the United Nations Economic and Social Commission for Asia
and the Pacific (ESCAP) to be represented here today on this auspicious occasion.

We are celebrating the official “Launch of the Incheon Strategy to ‘Make the Right Real’
for Persons with Disabilities” in Mongolia, together with our partner, the Asia-Pacific
Development Center on Disability (APCD).

This marks the first launch event of the Incheon Strategy in East and North-East Asia.
And, most significantly this event underscores the highest-level commitment of the
Government of Mongolia to the implementation of the Incheon Strategy.

Your Excellencies, on behalf of ESCAP, it is my privilege to extend heartfelt congratulations
to you all for your leadership.

In view of the enormity of the challenges, it is heartening to witness the exemplary strength of Mongolia's leadership commitment and government initiative.

Asia-Pacific is home to 650 million persons with disabilities, constituting 15 per cent of the total population living in the region. The number is expected to rise at higher rates in the next decades, due to population ageing and the consequences of natural disasters and other socioeconomic conditions. This projection certainly applies to Mongolia.

Although persons with disabilities have the right to a decent and productive life, they are still among the most marginalized population group in society. They live unseen, uncounted and unheard.

In recognition of the need to engage persons with disabilities meaningfully in processes for economic development and social progress, Mongolia together with other 61 Government of ESCAP, endorsed the Incheon Strategy to "Make the Right Real" for Persons with Disabilities in the Asia-Pacific, through their adoption of Commission resolution 69/13 of 1 May 2013. The Incheon Strategy builds on the Convention on the Rights of Persons with Disabilities.

It provides the region and the world, with the first set of regionally agreed disability-inclusive development goals with its 10 inter-related goals, 27 targets and 62 indicators.

The Incheon Strategy guides our Governments and other stakeholders during the current Asian and Pacific Decade of Persons with Disabilities, which started last year in 2013 and will end in 2022.

Excellencies,
Distinguished Guests,
Ladies and Gentlemen,

Mongolia is at the forefront of processes concerning the Convention and the Incheon Strategy.

First, Mongolia is among the few Governments in Asia and the Pacific that have ratified both the Convention on the Rights of Persons with Disabilities and its Optional Protocol and had done so already in 2009, a year after it came into force.

Second, since then, the Government has been establishing or amending more than 20 national disability legal and policy measures to protect, promote, and fulfill the rights of persons with disabilities in Mongolia.

The thematic areas covered include stringent enforcement of the employment quota system, disability statistics, subsidized provision of assistive devices, accessibility of the work environment, accessibility of the public transportation system, inclusive primary education, and the development of Mongolian sign language.

Furthermore, a disability perspective has been included in the National Comprehensive Development Strategy and the Mongolian Government's Action Programme.

At the intergovernmental level, the Government of Mongolia has been active in the drafting of the Incheon Strategy since 2010.

And, we fully share in Mongolia's pride that the leader of Mongolia's national disability movement has received regional recognition as ESCAP Promoter for the Asian and Pacific Decade of Persons with Disabilities.

Importantly, the Government of Mongolia is a member of the Working Group on the Asian and Pacific Decade of Persons with Disabilities, 2013-2022. The Working Group, established through ESCAP resolution 69/13 of last May, is the official advisory and governance mechanism of the present Decade. It provides technical guidance and support to ESCAP members and associate members for the effective implementation of the Incheon Strategy. The Working Group is the first such body of its kind in ESCAP – its membership is composed of equal representation from governments and civil society organizations: 15 members from each sector.

Just a month ago, your representative participated in the inaugural session of the Working Group held in Incheon, Republic of Korea, and joined in reviewing the draft road map on the implementation of the Incheon Strategy at all levels: national, subregional and regional. In fact, even earlier, Mr. Tsenden Oyunbataar, had attended a meeting last October which had discussed preliminary ideas for the preparation of the draft road map.

The draft road map, which was adopted by the Working Group, will be submitted to the 62 Governments of the ESCAP membership at this year's 70th session for consideration with a view to endorsing it.

One recommended national-level action is the translation of the Incheon Strategy into the national language and its conversion into accessible formats. We are gratified that, even before the Commission's endorsement of the road map, the Incheon Strategy has already been translated into Mongolian.

We should also like to congratulate Mongolia for the production of the national sign language version of the Incheon Strategy.

All these pioneering efforts clearly place Mongolia as a vanguard country in leading the forward charge towards progress in the new Asian and Pacific Decade of Persons with Disabilities.

Excellencies,
Distinguished Guests,
Ladies and Gentlemen,

In our collective striving for disability-inclusive societies, there are challenges to be overcome. How to effectively enforce the 20 plus national disability legal and policy measures to protect, promote, and fulfill the rights of persons with disabilities in Mongolia is one such challenge.

Closely linked with enforcement is monitoring and measurement. Disability statistics present complex problems of disability definition and methodology, which are intertwined with the purpose of data collection. We are confident that Mongolia's national statistical office will rise to this challenge in generating solutions worthy of close study by other member States. To overcome the challenges of implementation, there is a need for continuous efforts throughout the Decade to build and reinforce widespread awareness of the rights-based approach to disability among all sectors of society.

Such awareness for positive change of attitudes and behavior is a fundamental building block for multi-sectoral partnership to build a disability-inclusive Mongolian society in which no Mongolian is left behind and everyone contributes.

Such partnership, led by Government, will have to engage civil society, development organizations, and the private sector.

I would like to underscore that the involvement of the private sector can, to a significant degree, advance our common agenda: enable persons with disabilities to contribute to Mongolia's economic growth and social progress.

Today's commitment shines a bright beacon of hope that augurs well for Mongolia's achievement of national milestones in implementing the Incheon Strategy.

I am certain that the Government of Mongolia will forge new pathways through difficult, uncharted terrain for meaningful implementation of the Incheon Strategy.

Excellencies, Ladies and Gentleman, we look forward to your continued leadership.

Together, let us "Make the Right Real" for all Mongolians with disabilities, thereby improving the prospects for all persons with disabilities in Asia and the Pacific.

I thank you.

Эрхэм хүндэт Монгол Улсын Ерөнхий сайд Норовын Алтанхуяг,
Эрхэм хүндэт Монгол Улсын Хүн амын Хөгжил, Нийгмийн хамгааллын сайд Содномзундуйн Эрдэнэ,
Эрхэм хүндэт Монгол Улсын Эрүүл мэндийн сайд Нацагийн Удвал,
Ази Номхон Далайн Эдийн засаг, нийгмийн комиссын Ази, Номхон Далайн бүс нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн идэвхжүүлэгч , Цэдэнгийн Оюунбаатар
Монгол Улсын хүний эрхийн хорооны гүйцэтгэх захирал Жамсрангын Бямбадорж
Монгол улс дахь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Суурин төлөөлөгч Доктор Сои Ньюнт-У
Ази, Номхон Далайн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн захирал,
Хүндэт зочидоо,
Найз нөхөд болон хамтран зүтгэгчдээ,
Эрхэмсэг хатагтай, ноёд оо,

НҮБ-ын Ази, Номхон Далайн Эдийн засаг, нийгмийн комисс (ESCAP)-ыг төлөөлж энэхүү арга хэмжээнд оролцож байгаадаа талархаж байгаагаа илэрхийлье. Бид, Монгол Улс албан ёсоор Ази, Номхон Далайн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв (APCD)-тэй хамтран “Эрхийг бодит болгоё” 2013 - 2022 оны Инчеоны Стратегийг хүлээн авах арга хэмжээг хамтран тэмдэглэж байна. Зүүн болон Зүүн хойд Азид анх удаа Монгол Улс Инчеоны Стратегийг хэрэгжүүлэх ач холбогдол бүхий хариуцлагыг хүлээн авч байна.

Ази, Номхон Далайн эдийн засаг, нийгмийн комиссын нэрийн өмнөөс Та бүхэнд чин сэтгэлийн баяр хүргээд, энэхүү амаргүй асуудлыг шийдвэрлэхэд Монгол Улсын Засгийн газраас санаачлага гарган, манлайлан оролцож байгаад сэтгэл хангалуун байна.

Ази, Номхон Далайн бүс нутагт 650 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа нь бүс нутгийн нийт хүн амын 15 хувийг эзэлж байна. Энэ тоо ирэх жилүүдэд хүн амын насжилт, байгалийн гамшиг болон нийгэм, эдийн засгийн бусад нөхцөл байдлын үр дагавартай уялдан улам бүр нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд энэ нь Монгол Улсад нөлөөлөх магадлалтай юм.

Хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд зохистой бөгөөд бүтээлч амьдрах эрхээр хангагдсан хэдий ч, тэдний нийгмийн хамгийн эмзэг бүлэгт хамааруулсан хэвээр байгаа бөгөөд тэднийг үл тоосон, дуу хоолойг нь сонсдоггүй байдал үргэлжилсээр байна.

Нийгэм, эдийн засгийн үйл явцад Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодит оролцоог хангахын тулд, Монгол Улс Ази, Номхон Далайн Эдийн Засаг, Нийгмийн комиссын 2013 оны 5 дугаар сарын 1-ны 69/13 тоот тогтоолоор баталгаажсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Эрхийг бодит болгоё” Инчеоны Стратегийг уг комиссын гишүүн 61 улс орны хамт баталсан билээ.

Инчеоны стратеги нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах тухай конвенцэд тулгуурладаг бөгөөд бүс нутгийн болон олон улсын түвшинд хөгжлийн бэрхшээлийг хамруулсан хөгжлийг хангахад чиглэсэн харилцан хамаарал бүхий 10 зорилго, 27 зорилт, 62 шалгуураас бүрдсэн цогц баримт бичиг болсон билээ.

Инчеоны Стратеги нь 2013-2022 онуудад хэрэгжих Ази, Номхон Далайн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 10 жилийн хугацаанд Засгийн газрууд, бусад оролцогч талуудад удирдамж болох юм.

Эрхэм хүндэт төлөөлөгчдөө,
Хүндэт зочид, төлөөлөгчдөө,
Хүндэт хатагтай, ноёдоо,

Монгол Улс Конвенци болон Инчеоны Стратегийг хэрэгжүүлэхэд манлайлах үүрэг гүйцэтгэж байна.

Нэгдүгээрт, Монгол Улс бүс нутагтаа Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай Конвенци болон Нэмэлт протоколыг уг Конвенци хүчин төгөлдөр мөрдөгдсөний дараа жилд буюу 2009 онд соёрхон баталсан цөөн орнуудын нэг билээ.

Хоёрдугаарт, улмаар Монгол Улсын Засгийн газар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах, дэмжих болон эрхийг нь хангахад чиглэсэн 20 гаруй бодлого, хууль тогтоомжийг шинээр баталж, нэмэлт өөрчлөлт оруулж ажиллаж иржээ. Тухайлбал, ажил эрхлэлтийн квотын системийг нэвтрүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбогдсон статистик мэдээллийг гаргах, туслах төхөөрөмжөөр хангах, ажлын байрны орчны болон нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмж, анхан шатны боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, мөн дохионы хэлийг хөгжүүлэх зэрэг болно. Улмаар, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал Үндэсний хөгжлийн цогц бодлого болон Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөрт тусгалаа олжээ.

Монгол Улсын Засгийн газар 2010 оноос эхлэн Инчеоны Стратегийн төслийг боловсруулах бүс нутгийн үйл явцад идэвхтэй оролцож ирсэн билээ.

Мөн Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Холбооны тэргүүн Ази, Номхон Далайн эдийн засаг, нийгмийн комиссын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 10 жилийн идэвхжүүлэгчээр сонгогдсон нь бүс нутгийн түвшинд бахархалтайгаар хүлээн зөвшөөрөгдсөнийг дурдахад таатай байна.

Монгол Улсын Засгийн газар 2013-2022 онуудад Ази, Номхон Далайн бүсийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 10 жилийг хэрэгжүүлэх ажлын хэсгийн гишүүн орон бөгөөд Ази, Номхон Далайн эдийн засаг, нийгмийн комиссын өнгөрсөн 5 дугаар сарын 69/13 тоот тогтоолоор уг 10 жилийн хугацаанд зөвлөх болон удирдлагын албан ёсны хэрэгсэл хэмээн батлагдсан болно. Энэхүү баримт бичиг нь Инчеоны стратегийг амжилттай хэрэгжүүлэхэд Ази, Номхон Далайн эдийн засаг, нийгмийн комиссын гишүүн болон дэд гишүүн орнуудад техникийн арга зүйгээр хангаж, дэмжлэг үзүүлэх механизм юм.

Уг ажлын хэсэг нь Ази, Номхон Далайн эдийн засаг, нийгмийн комиссын хувьд ийм чиг үүрэг бүхий анхны бүтэц бөгөөд засгийн газар, иргэний нийгмийн ижил тэнцүү төлөөлөл буюу салбар тус бүрээс 15 гишүүн бүхий бүрэлдэхүүнтэй юм.

Одоогоос нэг сарын өмнө Монгол Улсын төлөөлөгч БНСУ-ын Инчеон хотод зохион байгуулагдсан ажлын хэсгийн уулзалтанд оролцож, Инчеоны Стратегийг үндэсний, дэд бүс нутгийн болон бүс нутгийн түвшинд хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг боловсруулахад оролцсон билээ. Энэхүү арга хэмжээнээс өмнө буюу өнгөрсөн 10 дугаар сард ноён Цэдэвийн Оюунбаатар уг төлөвлөгөөний төслийг боловсруулахтай холбогдсон санал санаачлагыг хэлэлцэх уулзалтад мөн оролцож байсан юм.

Уг төлөвлөгөөг ажлын хэсэг баталсанаар Ази, Номхон Далайн эдийн засаг, нийгмийн комиссын гишүүн 62 орны Засгийн газарт хүргүүлэх бөгөөд Комиссын 70 дугаар чуулганаар батлуулах зорилгоор хэлэлцүүлэх юм.

Уг төлөвлөгөөнд тусгасанчлан, Үндэсний хэмжээнд хэрэгжүүлбэл зохих нэг арга хэмжээ бол Инчеоны стратегийг үндэснийхээ хэл рүү орчуулж, мөн түүнчлэн хүртээмжтэй хэлбэрт хөрвүүлэх явдал юм. Монгол Улсын хувьд, Инчеоны Стратегийг Комиссын төлөвлөгөө батлагдахаас өмнө эх хэлнээ орчуулж, мөн түүнчлэн дохионы хэлээр хэвлэгдсэнд Монгол Улсад баяр хүргэх нь зүйтэй.

Энэ бүх хүчин чармайлт нь Монгол Улсыг Ази, Номхон Далайн бүс нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжигч тэргүүлэгч орны тоонд зүй ёсоор оруулж байна.

Эрхэм хүндэт төлөөлөгчдөө,
Хүндэт зочид, төлөөлөгчдөө,
Хүндэт хатагтай, ноёдоо,

Хөгжлийн бэрхшээлийн хүртээмжтэй нийгмийг хамтын хүчин чармайлтаар бүрдүүлэх үйлсэд саад тотгор оршсоор байгаа билээ. Монгол Улсад Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах, дэмжих, эрхийг нь хангахад чиглэсэн хууль, бодлогын арга хэмжээнүүдийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх, мөрдүүлэх асуудал чухлаар тавигдаж байна.

Хуулийг чандлан сахиулахад хяналт-шинжилгээ хийх мөн тоо мэдээг боловсруулах асуудал нягт уялдаатай явагдах ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн статистик мэдээ нь мэдээлэл цуглуулах болон хөгжлийн бэрхшээлийн нэр томъёо, түүнийг тодорхойлох арга зүй зэрэгтэй холбогдсон асуудлыг бий болгож байна. Монгол Улсын Үндэсний Статистикийн Газар нарийвчилсан судалгаа хийх замаар асуудлын шийдлийг олно гэдэгт бид итгэлтэй байна.

Инчеоны Стратегийн хэрэгжилтийн явцад тохиох саад бэрхшээлийг даван туулахын тулд, нийгмийн бүхий л салбарт эрхэд суурилсан чиг хандлагын талаарх мэдлэгийг бий болгох, хөгжүүлэх талаар 10 жилийн туршид хүчин чармайлт гаргах шаардлагатай байна.

Ийнхүү чиг хандлага, зан үйлийн эерэг өөрчлөлтийг авчрах мэдлэгийг бий болгох Монгол хүн бүрийн оролцоо, хувь нэмрийг багтаасан хөгжлийн бэрхшээлийн хүртээмжтэй нийгмийг бүрдүүлэхэд олон салбарын түншлэлийн суурийн эх үндэс болдог.

Энэхүү хамтын ажиллагаа нь Засгийн газар, иргэний нийгмийн байгууллага, хөгжлийн байгууллага болон хувийн хэвшлийн байгууллагуудыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудалд татан оролцуулах явдал юм.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудалд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх нь бидний нийтлэг зорилтыг хангахад буюу Монгол Улсын эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжил дэвшилд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангахад чухал ач холбогдолтой гэдгийг би онцлон тэмдэглэмээр байна.

Монгол Улсын өнөөгийн гаргаж буй хүчин чармайлт нь Инчеоны стратегийг хэрэгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг амжилттайгаар даван туулах итгэл найдварыг төрүүлж байна. Монгол Улсын Засгийн газар саад бэрхшээл бүхий асуудлуудыг шийдвэрлэж, Инчеоны Стратегийг бодитойгоор хэрэгжүүлэхийн тулд шинэ арга замуудыг нээж ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Эрхэм хүндэт хатагтай, ноёдоо, Та бүхнийг тасралтгүй манлайлж ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Бид бүгдээрээ Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг бодит болгож, улмаар Ази, Номхон далайн бүс нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аж байдлыг сайжруулахад хамтран ажиллахыг уриалж байна.
Баярлалаа.

REMARKS



MINISTRY OF HEALTH

Ms. Udval Natsag Minister, Ministry of Health of Mongolia

Honorable Prime Minister,
Members of the Parliament,
Dear Distinguished Guests,
Ladies and Gentlemen

May I send you my greetings of the day.

Today we are launching the third Asia Pacific Decade of Persons with Disabilities. It has been over 35 years since the WHO called the States to implement Community-based Rehabilitation for Persons with Disabilities in the Alma-Ata declaration "Health for All" of the World Health Assembly held in 1978, which declares that CBR is an integral part of primary health care.

In 2005, the 58th World Health Assembly passed a resolution called WHA58.23 Disability, including prevention, management and rehabilitation, where it urges the Member States to promote and strengthen community-based rehabilitation programs linked to primary health care and integrated into the health system.

Mongolia ratified the United Nations Convention on the Rights of Persons with Disabilities (UNCRPD) and Optional Protocol in May 13, 2009 and CBR is the way to implement the UNCRPD.

Mongolia translated the CBR Guidelines (WHO, ILO, UNESCO and IDDC -2010) into Mongolian and launched it officially in Mongolia. WHO and the AIFO-Italian association introduced CBR to Mongolia in 1991 and till now the AIFO is supporting it to implement successfully. According to tradition, Mongolians pay attention more on good desire and wishes. That's why we have given a brand name "Tegsh Duuren" to the CBR program meaning that Full Equality which is against invalidity. Mongolia has experience of 25 years implementing CBR in Mongolia.

Mongolia CBR - "Tegsh Duuren" program is being implemented in 21 aimags and Ulaanbaatar 9 districts with the order of the Minister of Health No. 216. CBR workers are bag feldshers, family and somon doctors. There is a CBR committee in every aimag and district, which is validated by the Governor's Resolution. For the duration of 25 years over 20,000

physicians and medical staff have been involved in the CBR stakeholders' training. Almost half of all persons with disabilities benefitted from the CBR program. For the purpose of supporting early identification of persons with disabilities and prevent secondary and tertiary difficulties, Public Health Information Centers, Rehabilitation Cabinets for persons with disabilities were established at the local level. Small-scale orthopedic workshops to produce simple rehabilitation aids using locally available materials are established at the local level as well. An orthopedic workshop parents' training has been organized at the local level and needed rehabilitation aids are produced for children with disabilities. We would like to mention Mr. Chapal Khasnabis, Officer, Public Health and Innovation Team, Essential Medicine and Health Products of WHO, who has trained our specialists and physicians on making rehabilitation aids using locally available materials. The technology you have taught us is still being implemented successfully.

One of the integral parts of CBR is early identification of disability using WHO methods "house-to-house". The CBR program has been collecting disability statistics every year. We are pleased to inform you that the form to collect disability statistics of the health sector has been just renewed with Order No. 450 of the Health Minister in 2013. In collaboration with Mongolia's CBR program, registration of persons with disabilities and its progress form is newly developed according to the WHO manual, "Training in the Community for Persons with Disabilities".

Since 2010, two credits of "CBR lesson" with 16 hours of theory and 32 hours of practice have been introduced to the fourth grade of social workers' class of the Public Health School of Health Science at the University of Mongolia with the support of Mongolia's CBR program and Ministry of Health. Starting this year a working group to develop a core training module of CBR was established. The core training module of CBR will be for all students of medical schools of private and state sectors and post-graduate training centers as well. As a result the physicians and doctors will be able to work with persons with disabilities and deliver rehabilitation services with good quality. We must confess that all these activities are the result of implementing CBR programs for 25 years in Mongolia. We would like to express gratitude to WHO, European Union and AIFO-Italian Association for supporting financially to implement the CBR program in Mongolia for 25 years.

In 2007, Health Science University opened a physiotherapy class under the Collaboration agreement between the Medical School of Japan Gunma University and Health Science University. Its first graduation happened in 2011. By 2012, there were 47 physiotherapists trained.

Every December of the year is "Health Promotion Month of Persons with Disabilities", validated by the Health Minister Order No. 453 of 2013. During the month health facilities at all level and multi-sector collaboration are promoted.

The monthly activities focus on increasing the accessibility of health care and service to persons with disabilities, reducing barriers related to health care and services, providing equal opportunity to integrate them into social life and promoting them to live independently.

As a result of the collaboration between the Ministry of Health, Rehabilitation and the Development Center of the Ministry of Population Development and Social Protection and

Mongolia CBR program, physicians and medical staff of 21 aimags and Ulaanbaatar's 9 districts are trained on medical screening of persons with disabilities. Screening has been organized among the general population for prevention purposes and has identified children with disabilities and registered them by their age, location and disability type.

A competition to become a "Disability Friendly Health Facility" has been organized every year among the health facilities.

To date, 156 state and private health facilities, 134 health professionals and nurses in 21 aimags, 162 in the private sector, 196 in health facilities of Ulaanbaatar City and 28 physiotherapists are delivering rehabilitation services to the public.

Till today we have gained a certain achievement in the disability sector, however multi-sector collaboration will play an important role for the well-being of general populations, especially improving quality of life and empowering persons with disabilities. We face lots of challenges. I have no doubt we can solve them with multi-sectoral collaboration.

The Government of Mongolia is launching the Incheon Strategy "Make the Right Real" – the third decade of Asia-Pacific and is going to develop a plan of action to implement it. In this period I am very pleased to express that the Ministry of Health will collaborate actively. We have the structure to implement Community-based Inclusive Development and Community-based Rehabilitation, which is the way to implement the United Nations Convention on the Rights of Persons with Disabilities. We appreciate the multi-sectoral collaboration.

Within the delegations there are local CBR committee heads, coordinators, persons with disabilities and representatives of Disabled People's Organizations. I would like to express my sincere thanks to those who contributed to the reputation of Mongolia at the global platform and wish you healthiness and happiness.

I would like to end my speech with this message: "Let your humanity for others come back to you with happiness and success."

Эрхэм хүндэт Ерөнхий сайдаа,
Улсын их хурлын эрхэм гишүүдээ,
Чуулганы хүндэт төлөөлөгчид, Хүндэт зочид,
Хатагтай, ноёдоо
Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэн мэндчилье.

Бид Ази Номхон далайн бүсийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гурав дахь Арван жилийг хүлээн авч байна. Мөн 1978 онд ДЭМБ “Бүх нийтийн эрүүл мэндийг дэмжих” Алма-Атагийн тунхаглалаар эрүүл мэндийн анхан шатны тусламжинд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагыг хэрэгжүүлэх уриа гарснаас хойш 35 жил болж байна.

2005 онд Дэлхийн эрүүл мэндийн 58 дугаар ассамблейгаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээл ба түүнээс урьдчилан сэргийлэх, удирдах, сэргээн засах” 58.23 тоот тогтоолд “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамт олонд түшиглэн сэргээн засах хөтөлбөрийг эрүүл мэндийн анхан шатны тусламжтай холбож, эрүүл мэндийн тогтолцоонд интеграцчилж бэхжүүлнэ” гэж заасан байдаг.

2006 онд НҮБ-ын 61-р Ерөнхий Ассамблейгаас батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци болон Нэмэлт протоколд Монгол улс 2009 оны 5-р сарын 13-нд нэгдэн орсон бөгөөд Конвенцийг хэрэгжүүлэх арга зам нь Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлага гэж тодорхойлсон байдаг.

2010 онд ДЭМБ, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, НҮБ-ын боловсрол, шинжлэх ухааны байгууллага, Олон улсын Хөгжлийн бэрхшээл ба хөгжлийн консорциум /IDDC/-ын хамтран боловсруулсан “Хамт олонд түшиглэн сэргээн засах” хандлагын Удирдамжийг Монгол хэлнээ хөрвүүлж, 2013 онд албан ёсоор танилцуулсан.

Манай улсын хувьд 1991 оноос Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамт олонд түшиглэн сэргээн засах “Тэгш Дүүрэн” хөтөлбөрийг ДЭМБ, АИФО – Италийн төрийн бус байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байгаа билээ. Өмнө нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тахир дутуу гэж нэрлэдэг байсныг та бүхэн мэдэх билээ. Монгол хүн амны билгээрээ байдаг. Тиймээс ч бид энэхүү хөтөлбөрөө Тахирыг тэгшилж, дутууг дүүргэх билэгдэлтэйгээр “Тэгш Дүүрэн” гэж нэрлэсэн юм. Хэдийгээр билэгдлийн нэр өгсөн боловч угтаа энэхүү хөтөлбөр нь өнөөдрийн бидний ярилцаж буй сэдвийг Монгол улс 25 жилийн өмнө хэрэгжүүлж эхэлсэн, өөрийн орны онцлогт тохируулж хэрэгжүүлж буй туршлагатай орон юм.

Өдгөө “Тэгш Дүүрэн” хөтөлбөр Монгол улсын 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүрэгт ЭМ-ийн сайдын 216 тоот тушаалаар үндэсний хөтөлбөр болон хэрэгжиж байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгчид нь багийн бага эмч, өрх, сумын эмч нар юм. Мөн аймаг, дүүрэг болгонд “Тэгш Дүүрэн” хөтөлбөрийн хороо, зохицуулагч нар Засаг даргын захирамжаар батламжлагдан ажиллаж байна. Энэхүү 25 жилийн хугацаанд давхардсан тоогоор 20 гаруй мянган эмч, эмнэлгийн ажилтан Хамт олонд түшиглэсэн сэргээн засалтын сургалтанд хамрагдаж, нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 50 гаруй хувь нь “Тэгш Дүүрэн” хөтөлбөрөөс ашиг хүртсэн байдаг. Хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрт илрүүлж, хоёрдогч, гуравдагч хүндрэлээс сэргийлэх зорилгоор аймаг бүрт ХБИ-ийг мэдээллээр хангах Нийгмийн эрүүл мэндийн мэдээллийн төв, Сэргээн засалтын кабинетуудыг байгуулсан. Мөн орон нутгийн олдоц ихтэй материал ашиглаж сэргээн засалтын туслах хэрэгслүүд хийх жижиг

оврын ортопедийн цехүүдийг аймаг бүрт байгуулсан. Энэхүү цехээ түшиглэж тархины саатай хүүхэдтэй эцэг эхчүүдэд сургалт зохион байгуулан, хэрэгтэй сэргээн засалтын туслах хэрэгслүүдийг хийж өгч байна. Энэхүү аргад манай эмч, мэргэжилтнүүдийг анх 1999 онд сургасан ДЭМБ-ын Суурь анагаах ухаан, эрүүл мэндийн бүтээгдэхүүний хэлтсийн нийгмийн эрүүл мэнд, инновацийн багийн мэргэжилтэн ноён Чапал Хаснабист “таны сургасан технологи одоог хүртэл амжилттай хэрэгжиж байгаа”-г дуулгахад таатай байна.

Хөтөлбөрийн бас нэг зайлшгүй чухал хэсэг бол ДЭМБ-ын гэрээс гэрт аргаар илрүүлэлтээ хийх явдал бөгөөд “Тэгш Дүүрэн” хөтөлбөр ХБИ-ийнхээ статистикийн тоон мэдээллээ цуглуулдаг болоод хэвшсэн билээ. Дашрамд дурдахад 2013 онд ЭМ-ийн сайдын 450 тоот тушаалаар Эрүүл мэндийн салбарын албан ёсны статистикийн мэдээ тайлан гаргах, мэдээлэх тайлангийн маягтыг шинэчилснийг дуулгахад таатай байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамт олонд түшиглэн сэргээн засах “Тэгш Дүүрэн” хөтөлбөртэй хамтран Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүртгэл болон Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ахиц дэвшлийг үнэлэх маягтыг шинээр боловсруулсан бөгөөд эдгээр статистикийн бүртгэлийн маягтыг ДЭМБ-ын “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хамт олонд түшиглэн сургах” 35 багц гарын авлага дээр үндэслэж хийсэн юм.

2010 оноос ЭМЯ, “Тэгш Дүүрэн” хөтөлбөртэй хамтарч ЭМШУИС дээр Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагыг танилцуулах хичээл орж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар 16 цагийн онол, 32 цагийн дадлагын ажил, нийт 2 кредиттэй сургалт Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн эрүүл мэндийн нийгмийн ажилтан мэргэжлээр сурч буй 4-р дамжааны оюутнуудад орж байна. Мөн энэ оноос эхлэн Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагын цөм хөтөлбөр боловсруулахаар ажлын хэсэг гаран ажиллаж байна. Энэхүү Цөм хөтөлбөр гарснаар эмч, эмнэлгийн ажилтан бэлтгэдэг хувийн болон улсын их, дээд сургуулиудын оюутнууд болон Мэргэжил дээшлүүлэх институтээр мэдлэгээ дээшлүүлж буй эмч нар маань Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагаар мэдлэг мэргэжилтэй болох юм. Ингэснээр бид эмч нарыг араас нь хөөн сургах биш, оюутан байх үедээ хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй ажиллахад нь сургах юм. Бид үүнийг бодлогын шинжтэй ажил гэж үзэж байна. Энэ бол “Тэгш Дүүрэн” хөтөлбөр 25 гаруй жил Монгол улсад хэрэгжсний үр дүн гэж бодож байна. Энэхүү хөтөлбөрийг энэ 25 гаруй жилийн хугацаанд үргэлж дэмжиж, хамтран ажиллаж байгаа ДЭМБ, Европын Холбоо, Италийн АИФО Төрийн бус байгууллагад талархаж байгаагаа илэрхийлье.

Мөн 2007 онд Японы Гунма Их Сургуулийн Анагаах Ухааны салбар сургууль, ЭМШУИСургуультай хамтын гэрээ байгуулан хөдөлгөөн засалч мэргэжилтнийг бэлтгэн 2011 онд анхны төгсөлтөө хийж 2012 оны байдлаар 47 хөдөлгөөн засалч бэлтгэгдээд байна.

Жил бүрийн 12 дугаар сарыг “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийг дэмжих сарын аян” болгох шийдвэрийг Эрүүл мэндийн сайд гаргаж 2013 оны 453 тоот тушаалаар удирдамж баталсны дагуу сарын аяныг бусад салбар болон яамдын төлөөлөл хамтран бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад зохион байгуулсан.

Уг сарын аяны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахтай холбоотой учирч байгаа саад бэрхшээлийг багасгах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хараат бус байдал, эрүүл мэнд, нийгмийн харилцаанд тэгш оролцох боломжийг нь хангах зорилгоор ажлуудыг зохион байгууллаа.

Эрүүл мэндийн яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны харьяа “Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төв” “Тэгш дүүрэн” хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр 21 аймаг, 9 дүүргийн сэргээн засах эмч, мэргэжилтнүүдэд үзлэг хийх арга, аргачилалын сургалтанд хамруулж сургагч багш бэлтгэн хөгжлийн бэрхшээлийг эрт илгүүлэх урьдчилсан сэргийлэх үзлэгийг улс даяар зохион байгуулж, илэрсэн хөгжлийн хоцрогдолтой хүүхдүүдийг нас, харьяалал болон хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр нь ангилан дүнг нэгтгэн гаргасан.

Эрүүл мэндийн тусламж үзүүлдэг байгууллагуудын дунд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй эмнэлэг шалгаруулах уралдааныг жил бүр зохион байгуулж байна.

Өнөөгийн байдлаар улсын ба хувийн хэвшлийн нийт 156 байгууллагад мөн сэргээн засах тусламжийг 21 аймагт 134, хувийн хэвшилд 162, улаанбаатар хотын төрийн өмчит эмнэлгийн байгууллагад 196 эмч, сувилагч, 28 хөдөлгөөн засалч нар ажиллаж байна.

Өнөөдрийг хүртэл бидний олсон амжилт багагүй хэдий ч цаашдаа бүх нийтийг эрүүл байлгах, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, тэднийг эрх мэдэлжүүлэхэд салбар хоорондын хамтын ажиллагаа онцгой үүрэгтэй. Бидэнд дутагдаж байгаа зүйл их бий. Үүнийг бид хамтын ажиллагаагаар шийдвэрлэнэ гэдэгт би эргэлзэхгүй байна.

Монгол улсын Засгийн Газар Ази-Номхон далайн бүсийн гурав дахь Арван жил буюу “Эрхийг бодит болгоё” Инчеоны стратегийг хүлээн авч, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулан хэрэгжүүлэх гэж байгаа энэ цаг үед ЭМЯ идэвхтэй хамтран ажиллана гэдгээ илэрхийлэхэд таатай байна. ХБИ-ийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийг хэрэгжүүлэх арга болох Хамт олонд түшиглэн сэргээн засах буюу Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх хандлагыг хэрэгжүүлэхэд бидэнд бүтэц нь бий. Бид салбар хооронд хамтран ажиллахдаа таатай байх болно.

Энд хуран цугларсан зочид төлөөлөгчид дотор “Тэгш Дүүрэн” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлдэг дарга, зохицуулагч, Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, мөн хамтран ажилладаг Төрийн бус байгууллагуудын төлөөлөгч нар ирсэн байгаа бөгөөд Ази-Номхон далайн бүсэд Монгол улсын нэрийг Та бүгдийн хичээл зүтгэлээр гаргаж байгаа гэдгийг дурдаад та бүхэнд аз жаргал, эрүүл энхийг хүсч, талархаж байгаагаа илэрхийлье.

“Бусдад хийсэн буян тань буцаад танд ирэх болтугай” гэсэн сайхан ерөөлөөр үгээ дуусгая.

Сайн үйлс дэлгэрэх болтугай.

REMARKS



Mr. Akiie Ninomiya, Executive Director, Asia-Pacific Development Center on Disability

Your Excellency Speakers,
Distinguished Guests,
Ladies and Gentlemen,

I would like to express my warm greetings to everyone here today at this important workshop. It is my pleasure to be here and a privilege to be able to speak.

The launching ceremony of the Incheon Strategy to “Make the Right Real” for Persons with Disabilities 2013-2022 in Mongolia is an important day not only in Mongolia but also for the whole Asia-Pacific region.

The Asia-Pacific Development Center on Disability (APCD) is a regional center on disability and development, having endorsed by the United Nations Economic and Social Commission for Asia and the Pacific (ESCAP) as the regional center to promote regional cooperation according to the Incheon Strategy to Make the Right Real, 2013-2022.

APCD is proud to collaborate with the Government of Mongolia on the important regional policy on disability and development.

This document is a blueprint which can assist all of us to work together as one to achieve our mutual goal of embedding rights for persons with disabilities once and for all across the Asia-Pacific region.

In this connection, APCD is proud to support the production of the Incheon Strategy to “Make the Right Real”, 2013-2022, to be available not only in the Mongolian language, but also in such important accessible formats as audio, Mongolian sign language and braille.

We do hope that the Incheon Strategy in a variety of formats will enhance the recognition of accessibility in many aspects.

APCD looks forward to further collaboration with the Mongolian Government in the years ahead to 'Make the Right Real'!

To close, may I once again thank you all for the opportunity to speak and I would like to wish the workshop organizers and participants a most productive day ahead.

Thank you.

Хүндэт зочид, төлөөлөгчидөө
Эрхэмсэг хатагтай, ноёдоо,

Энэхүү чухал арга хэмжээнд хүрэлцэн ирсэн Та бүхэнд чин сэтгэлийн халуун мэндчилгээ дэвшүүлье. Мийний бие энэ арга хэмжээнд оролцож, үг хэлэх завшаан тохиосонд талархаж байгаагаа илэрхийлье.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Эрхийг бодит болгоё” 2013 - 2022 оны Инчеоны стратегийг Монгол Улсад хүлээн авах үндэсний уулзалт нь зөвхөн Монгол Улс төдийгүй Ази, Номхон Далайн бүс нутгийн хэмжээнд чухал ач холбогдолтой арга хэмжээ юм.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, Номхон Далайн Эдийн Засаг, Нийгмийн Комисс “Эрхийг бодит болгоё” 2013-2022 оны Инчеоны стратегийн хэрэгжилтийг дэмжих, бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор Ази, Номхон далайн бүсийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийг байгуулсан билээ.

Тус төв нь хөгжлийн бэрхшээл ба хөгжлийн чухал асуудлаар Монгол Улсын Засгийн газартай тогтоож буй хамтын ажиллагааг сайшаан хүлээн авч байна.

Энэхүү баримт бичиг нь Ази, Номхон Далайн бүс нутгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах нийтлэг зорилгодоо хүрэх бидний хүчин чармайлтыг дэмжих удирдамж бүхий баримт бичиг юм.

Ази, Номхон далайн бүсийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв нь “Эрхийг бодит болгоё” 2013 - 2022 оны Инчеоны стратегийг зөвхөн Монгол хэл дээр орчуулснаар төдийгүй аудио хэлбэр, дохионы хэл болон Брайл зэрэг нэн чухал хэлбэрээр хүртээл болгоход дэмжлэг үзүүлснийг тэмдэглэн хэлэхэд таатай байна. Улмаар энэхүү Инчеоны Стратегийн баримт бичгийг янз бүрийн хэлбэрээр хүртээл болгосноор хөгжлийн бэрхшээлийн хүртээмжийг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулна гэдэгт бид итгэлтэй байна.

Цаашид тус төв нь “Эрхийг бодит болгоё” стратегийг хүрээнд Монгол Улсын Засгийн газартай хамтран ажиллах болно.

Үг хэлэх боломж олгосонд болон энэхүү сайхан үйл ажиллагаанд оролцогч, зохион байгуулагчдад дахин талархалаа илэрхийлье.

REMARKS



Mr. Byambadorj Jamsran Chief Commissioner, National Human Rights Commission of Mongolia

Ladies and Gentlemen,

I would like to greet you all who are here attending the national seminar and wish you all the best!

It is an important historical event that Mongolia has acknowledged and decided to implement the Incheon Strategy to “Make the Right Real” for Persons with Disabilities in Asia and Pacific from 2013-2022, adopted by the United Nations Economic and Social Commission for Asia and the Pacific in November 2012.

Following the adoption of the new Constitution of Mongolia and a number of laws and acts, ratification and accession to over twenty international human rights treaties and conventions, Mongolia established a legal guarantee to ensure the human rights and freedoms in the country and also obliged its commitment to fulfill the human rights and freedoms before its people as well as the international community.

The Constitution of Mongolia states that “The State is responsible to the citizens for the creation of economic, social, legal, and other guarantees ensuring human rights and freedoms, for the prevention of violations of human rights and freedoms, and restoration of infringed rights”. It is not a mere declaration, but it is a milestone provision that shall be observed in all activities of the State.

Now it is crucial to make human rights and freedom real. I believe that today’s event will show us a good example and I am very happy about it. Persons with disabilities expect more attention, more opportunities and needs from the state, public, and from us. We shall always keep in mind that persons with disabilities, same as everyone else, will be able to participate in social life as long as those opportunities are ensured because persons with disabilities do not want to just stay home and be taken care of by society, their families, and friends, or someone else. They also want to, the same as everybody, study, get education, and work, and participate in social life actively, and compete in sports, which can motivate and inspire them to develop themselves as well as society.

The National Human Rights Commission collaborates with government and non-government organizations working in the field of protection and promotion of the rights of persons with disabilities. Within this framework of cooperation, we receive and resolve the complaints lodged by persons with disabilities, and undertake inquiries and monitoring, make analysis on the situation, and incorporate the findings into our annual report, and issue recommendations and demands for solutions by government bodies.

Ladies and gentlemen!

1. First of all, we shall study the social root causes of disabilities, and take preventative measures with policy. Mongolia is a peaceful country where war crimes, armed conflicts, and public disorder are unlikely to happen. We should be proud of that. Despite this fact, the number of persons with disabilities does not decrease. Main factors of disabilities are air pollution stemming from mining exploitation, soil erosion, urban fog and air pollution, chaotic traffic jams, barriers for pedestrians (no pass way or sidewalk, slippery in winter time), unsafe conditions at the workplace, technical standards and norms, and widespread alcoholism in society. We should pay special attention to those causes specifically derived from human activities such as newborn infants with mental disabilities or with organ impairments, traffic accidents, and technical and workplace incidents. We shall take effective measures in order to prevent them.

2. It is necessary to identify our priorities in order to make the rights of persons with disabilities real.

A. Issue of education and obtaining a career/profession. The Commission undertook an inquiry into the “implementation of the right to education of students with disabilities” at six special purpose schools in the capital city from 2011-2012.

Through the inquiry, the Commission uncovered shortcomings including a failure to build up a favorable and accessible environment to live and study for students with disabilities. This was due mainly to the dilapidated condition of the school building and the government failure to allocate the necessary funding to undertake the repairs and modifications necessary, as well as insufficient human resources of professional teaching staff, a huge age gap between the students studying in the same class, and insufficient teaching aids. Another issue was that vocational training which is most needed and plays an important role for those who need to find their social position after their graduation was closed down.

As a result, the Commission concluded that the state failed to fulfill its obligation to respect, promote, and fully ensure human rights and issued demands comprised of 16 provisions to the Ministry of Education and Science, the Ministry of Labour, the Ministry of Population Development and Social Welfare, and the Ministry of Health, requesting them to take certain measures. In response, the ministries have started taking necessary steps to address the issues.

B. Issue of transport (public transportation, roads, traffic lights), and accessibility (elevator, ramps, and other standards) in order to participate in social life.

The National Human Rights Commission of Mongolia and General Agency for Specialized Inspection undertook a joint inquiry into newly-built residential apartments in Ulaanbaatar in order to assess their compliance with special needs and requirements stipulated under the UN Convention on the Rights of Persons with Disabilities, and then to issue recommendations and proposals, based on the findings, to the competent authorities for the solution in June 2013.

Within this framework of inquiry, we checked the implementation of the following standards: "Roads and technical requirements for pedestrians and persons with disabilities" MNS 5682:2006; "Guidance for planning roads for pedestrians and persons with disabilities" MNS 6056:2009; "Appropriate spacing, environment, and main requirements which ensure the needs of persons with disabilities in the planning of residential apartment" MNS 6055:2009 at 11 buildings above 17 floors and 24 buildings below 17 floors.

Based on the Commission's inquiries and research, survey on the implementation of the rights of persons with disabilities and their complaints, it is viewed that their rights are still being violated due to lack of access to buildings, and lack of access to information and communication.

The National Association of Persons with Wheelchair and other NGOs working for the rights of persons with disabilities proposed the Commission to cooperate with them on the issue of ensuring accessibility for persons with disabilities. Along with the NGOs, the Commission submitted a proposal to the Cabinet Secretariat of Government, ministries, and the Governor's Cabinet of Ulaanbaatar City to take necessary measures to eliminate the barriers faced by persons with disabilities to participate in social life like everyone else, and to ensure the implementation of provisions of the international human rights treaties and conventions Mongolia is a party to, the Constitution of Mongolia, other relevant laws and standards which require the accessibility of both inner and outer structure of the building, including roads and ramps.

In September 2013, we checked the outcome of this proposal through photo documentation taken as ongoing observation found that the State Palace, 12 ministries out of 16, Khangarid Palace of Governor's Cabinet of Ulaanbaatar City had built a ramp in order to ensure access to their respective buildings for persons with disabilities. Unfortunately, most of these ramps did not meet the standards and requirements for persons with disabilities.

C. Access to information and communication.

I hope that today's event will be a good model. Through ensuring the right to access to information - having enough information about social events and activities - persons with disabilities will be able to manage their personal life and work and to actively participate in social life. We should accept that there is a drawback on this situation.

D. There is a need to address and resolve the issue of treatment and protection of vulnerable groups, specifically persons with mental disabilities. Despite the fact that the Commission has been addressing this issue to competent government authorities many times, there is still no progress. The Commission included the issue of "building a national care center for persons with mental disabilities" and gave specific recommendations in its "Annual reports on situation of human rights and freedoms in Mongolia" for 2007 and 2011, which were submitted to the Parliament (State Great Hural).

The Sub-committee on Human Rights and Standing Committee on Legal Affairs of the Parliament considered the Commission's report and ordered the Government to take immediate action to solve the issue of establishing the National care center for persons with mental disabilities by Resolution No. 2 of the Standing Committee on Legal Affairs dated 2013. Unfortunately, no action has been taken to date.

E. It is necessary to increase the participation of civil society and commission them to execute some duties of state, and strengthen cooperation between the state and civil society. It is the civil society who knows more about joys and pains of persons with disabilities as well as their problems and it is civil society who voluntarily joins and commits to work for the well-being and rights of persons with disabilities. It is civil society who has more information and knows what to do for persons with disabilities. It is crucial to receive requests and proposals of civil society when adopting state policies and laws. In order to do so, the state has a duty to pay attention to building their capacities.

May the good deeds be everywhere!

Хүндэт зочид, төлөөлөгчид, ноёд хадагтай нараа.

Энэхүү уулзалтад хүрэлцэн ирсэн та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэж, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, Номхон далайн бүсийн эдийн засаг, нийгмийн комиссоос 2012 оны 11 дүгээр сард баталсан “2013-2022 онд Ази, Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг бодит болгоё” Инчеоны стратегийг хүлээн авч, хэрэгжүүлэхээр болж байгаа нь түүхэн чухал үйл явдал билээ.

Монгол Улсын шинэ Үндсэн хууль, шинээр батлагдсан олон арван хууль, эрх зүйн акт, соёрхон баталсан болон нэгдэн орсон 20 гаруй олон улсын гэрээ, конвенц нь манай орон хүний эрх, эрх чөлөөг эдлүүлэх хууль зүйн баталгааг үндсэнд нь бүрдүүлж чадсаныг, мөн энэ талаар өөрийн иргэдийн өмнө түүнчлэн дэлхийн нийтийн өмнө амлалт авсны гэрч гэж хэлж болно.

Монгол Улсын Үндсэн хуульд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”. гэж заасан нь тунхаглал биш төрийн бүхий л үйл ажиллагаанд заавал баримталж байх тулгуур заалт билээ.

Одоо гагцхүү хүний эрх, эрх чөлөөг бодитой болгох нь чухал болоод байна. Өнөөдрийн энэ арга хэмжээ бидэнд үлгэр дууриал болно хэмээн маш их олзуурхаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс төрөөс, нийгмээс, биднээс илүү их анхаарал, нэмэлт нөхцөл боломж, хэрэгцээг хүлээж байдаг. Энэ нөхцөл боломж хир зэрэг бүрдэнэ тэр хэмжээгээр эдгээр хүмүүс нийгмийн харилцаанд бидэнтэй мөр зэрэгцэн оролцдог гэдгийг ямагт санаж ажилламаар байна. Учир нь хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмээр, гэр бүл, найз нөхөд, хэн нэгнээр тэжээлгээд гэртээ суугаад байхыг огтхон ч хүсдэггүй юмаа. Тэд бидэнтэй адил сурч, боловсрол, мэргэжил эзэмшиж, ажил хөдөлмөр эрхэлж, улс төр нийгмийн амьдралд идэхтэй оролцож, спортоор уралдаж байж сэтгэл санаа нь өөдрөг нийгмийг, өөрийгөө хөгжүүлэх чин хүсэлтэй байдаг шүү дээ.

Хүний эрхийн Үндэсний Комисс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих асуудлаар ажилладаг төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран энэ хүрээнд тэдний гомдлыг хүлээн авч шийдвэрлэж, хяналт шалгалт, хяналт шинжилгээ, судалгаа хийж, жил бүрийн илтгэлдээ оруулж, шаардлага зөвлөмж өгч, төрийн холбогдох байгууллагуудаар шийдвэр гаргуулан ажиллаж байна.

Эрхэм хатагтай ноёд оо!

1. Бид юуны өмнө хөгжлийн бэрхшээлтэй болж байгаа нийгмийн шалтгаан нөхцлийг судалж, түүнээс урдчилан сэргийлэх ажлыг бодлоготойгоор хиймээр байна. Манай орон дайн байлдаан, зэвсэгт мөргөлдөөн, нийгмийг хамарсан эмх замбараагүй байдал тулгараад байдаггүй энх амгалан тайван улс билээ. Бид үүгээрээ бахархах ёстой. Гэсэн атлаа хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо буурахгүй байна. Уул уурхайн олборлолтоос шалтгаалсан агаарын бохирдол, газрын эвдрэл, төв суурин газрын утаа, гудамж замын хөдөлгөөний эмх замбараагүй байдал, явган хүн зорчих бэрхшээл (явган хүний зам, гарцгүй, өвөл халтиргаа гулгаа үүсдэг,) ажлын байрны аюултай нөхцөл байдал, техник технологийн горим, нийгмийн хавтгайрсан архидалт зэрэг олон хүчин зүйл энэ асуудлын голлох шалтгаан болж байна. Оюуны хомсдолтой болон

эрхтний гажигтай төрөлт, автын осол, ахуйн болон ажлын байрны осол гэмтэл зэрэг хүний хүчин зүйлээс хамааралтайгаар хөгжлийн бэрхшээлтэй болж байгааг онцгойлон анхаарч бодитой, үр дүнтэй ажил хиймээр байна.

2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ эрхийг бодитой болгохын тулд эн тэргүүнд авах арга хэжээ, тэргүүлэх чиглэлээ тодорхойлох шаардлагатай байна.

А. Сурч боловсрох, мэргэжил эзэмших асуудал. Комисс 2011-2012 онд Нийслэлийн тусгай хэрэгцээт боловсролын 6 сургуульд суралцаж буй “хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилт”-д хяналт шалгалт хийсэн юм.

Шалгалтаар сургуулиудын барилга байгууламж хуучирсан, төрийн зүгээс иж бүрэн засвар хийх санхүүжилтийг олголтгүй өдийг хүрч, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирсон амьдрах, суралцах хүртээмжэй орчныг бүрдүүлж чадаагүй, мэргэжлийн боловсон хүчин хангалтгүй, нэг ангид суралцагчдын насны хэт зөрүүтэй байдал, сургалтын материал хүрэлцээгүй зэрэг дутагдал илэрсэн юм. Мөн энд суралцаж төгсөөд нийгэмд өөрийн байр сууриа олоход хамгийн чухал үүрэгтэй байсан мэргэжил сургалтын төвийг нь татан буулгасан байв.

Хяналт шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдлыг үндэслэн төр хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах үүргээ бүрэн хэрэгжүүлж чадахгүй байгаад дүгнэлт хийж, тодорхой арга хэмжээ авах талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөрийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайд нарт 16 заалт бүхий шаардлагыг хүргүүлж, шаардлагын мөрөөр холбогдох яамдаас тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Б. Нийгмийн харилцаанд оролцохын тулд зорчих (нийтийн тээвэр, зам, гэрлэн дохио) нэвтрэх (цахилгаан шат, налуу шат бусад стандарт) боломжийн асуудал.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар хамтран Улаанбаатар хотод шинээр баригдаж буй иргэний барилга байгууламжууд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцид заасан тусгай хэрэгцээ, шаардлагад нийцэж буй эсэхийг үнэлж, тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн холбогдох байгууллагуудад санал, зөвлөмж гаргаж, хэрэгжилтийг хангуулах зорилгоор 2013 оны 06 дугаард хяналт шалгалт хийсэн юм.

Энэхүү шалгалтын хүрээнд нийслэлд баригдаж буй 17 давхраас дээш 11 барилга, 17 давхраас доош 24 барилга байгууламжид “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, техникийн шаардлага” MNS 5682:2006; “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS 6056:2009; “Иргэний барилга төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин, үндсэн шаардлага” MNS 6055:2009 стандартуудын хэрэгжилт хэрхэн хангагдаж байгааг шалгасан.

Комиссоос хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хэрэгжилтийн талаар удаа дараа хийсэн хяналт шалгалт, судалгаа болон тэднээс ирүүлсэн гомдлоос үзэхэд барилга байгууламж, орчны хүртээмжгүй байдал, мэдээлэл харилцаа холбооны хүртээмжгүй байдлаас шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх зөрчигдсөөр байгаа нь харагдсан болно.

Комисст хандаж хүртээмжтэй орчныг бүрдүүлэхэд анхаарч, хамтран ажиллах тухай хүсэлтийг Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн

чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудаас ирүүлсний дагуу төрийн бус байгууллагуудтай хамтран Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар, яамд, Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусдын нэгэн адил нийгмийн харилцаанд бүрэн дүүрэн оролцоход учирч буй саад бэрхшээлийг арилгах, барилгын доторхи болон гаднах байгууламж, зам, шат зэргийг тэдэнд хүртээмжтэй болгох тухай Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийн заалт, Монгол Улсын Үндсэн хууль, хууль тогтоомж, стандартын биелэлтийг хангуулах талаар тодорхой арга хэмжээ авахуулах саналыг хүргүүлсэн билээ.

Саналын үр дүнг 2013 оны 9 сард хөндлөнгийн ажиглалт хэлбэрээр фото зурагжуулалт хийх аргыг ашиглан шалгахад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг төрийн байгууллагад саадгүй нэвтрэн орох нөхцлийг Төрийн ордон, 16 яамны 12 яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хангарьд ордон налуу замтай болсон байна. Харамсалтай нь эдгээр замын нилээд нь стандартын шаардлага хангахааргүй болсон байна.

В. Мэдээлэл олж авах, харилцах боломжийн асуудал.

Өнөөдрийн энэ арга хэмжээ загвар болно байхаа. Мэдээлэл авах эрх, нийгэмд болж байгаа үйл явцын талаар хангалттай мэдээлэлтэй байснаараа эдгээр хүмүүс өөрийн ажил амьдралаа зохицуулах нийгмийн амьдралд идэвхтэй оролцох боломж бүрдэнэ. Энэ байдал манай оронд тун хангалтгүй байгааг хүлээн зөвшөөрөх ёстой.

Г. Нийгмийн эмзэг хэсэг, тэр дундаа сэтгэцийн өвчтэй хүмүүсийн асрамж, хамгааллын асуудлыг шийдэх шаардлагатай байна. Комисс энэ асуудлаар төрийн холбогдох байгууллагуудад олон удаа хандаж байгаа боловч ахиц гарахгүй байна. Комиссоос Улсын Их Хуралд өргөн барьдаг “Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх” 2007, 2011 онуудын илтгэлдээ “сэтгэцийн өвчтэй хүмүүст зориулсан улсын асрамжийн газар байгуулах” асуудлыг тусгаж, тодорхой санал зөвлөмжийг өгсөөр ирсэн юм.

Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хороо, Хууль зүйн байнгын хороогоор комиссын илтгэлийг хэлэлцээд Хууль зүйн байнгын хорооны 2013 оны 2 дугаар тогтоолоо Сэтгэцийн эмгэгтэй хүмүүст зориулсан асрамжийн газар байгуулах асуудлыг нэн даруй шийдвэрлүүлэхээр Засгийн газарт чиглэл болгосон ч одоог хүртэл шийдэгдээгүй байна.

Д. Иргэний нийгмийн байгууллагын орлоог нэмэгдүүлж, төрийн зарим үүргийг тэднээр гүйцэтгүүлэх, төр, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх хэрэгтэй байна. Өнөөгийн нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн зовлон жаргал, тэдэнд тохиолддог бүхий л асуудлыг мэддэг, тэдний эрх ашгийн төлөө сайн дураараа нэгдэж, сэтгэлээрээ ажилладаг хүмүүс бол иргэний нийгмийн байгууллагынхан билээ. Хамгийн их мэдээлэлтэй байж, авах арга хэмжээг тэд хэнээс ч илүү мэддэг. Төрийн бодлого, хууль тогтоомж батлан гаргахдаа тэдний хүсэлт, саналыг түлхүү авч баймаар байна. Үүний тулд тэдний чадавхийг нэмэгдүүлэхэд төр анхаарах үүрэгтэй.

Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай

REMARKS



Dr. Salik Govind
Officer-In-Charge
World Health Organization

Salutations!

His Excellency, The President of Mongolia,

Honorable Prime Minister of Mongolia, Mr. Altankhuyag

Honorable, Mr. Enkhbold, Speaker of Parliament

Honorable Minister of Population Development and Social Protection

Honorable Minister of Health Dr. Udval

Mr. Patrik Andersson, Chief, Social Integration Section, UNESCAP

Mr. Akiie Ninomiya, Executive Director, Asia- Pacific Development Center on Disability

Mr. Oyunbaatar Tseden, President, Mongolian National Federation of Disabled People's Organization

Distinguished Participants, Ladies and Gentlemen,

On behalf of the World Health Organization, it is a great pleasure for me to participate at the National workshop on "Make the Right Real".

In recent years, there have been several high level meetings and conventions both at the United Nations General Assembly and the World Health Assembly to Make the Right Real for people.

Following the UN Convention on the Rights of Persons with Disabilities (CRPD), which came into effect in May 2008, the World Health Organization in collaboration with the World Bank released the World Report on Disability in 2011.

In summary, the World Report highlighted the following:

- Over one billion people globally experience disability (1 in 7 persons) and the number is growing due to the ageing population, an increase in chronic diseases, injuries from road traffic accidents, disasters etc.

- 15% of this number (110-190 million adults) have very significant difficulties in functioning.
- Poorer health than the general population
- Lower educational achievements
- Less economic participation
- Higher rates of poverty
- Increased dependency and reduced participation

In terms of health care, persons with disabilities have the same health care needs as others but they are:

- 2X more likely to find inadequate health care providers, skills and facilities
- 3X more likely to be denied health care
- 4X more likely to be treated badly in the health care system
- Half of persons with disabilities cannot afford health care; they are 50% more likely to suffer catastrophic health care expenditure. These out-of-pocket health care payments can push a family into poverty.
- 70 million persons with disabilities need a wheelchair, only 5-15% have access to one, similarly 360 million people have moderate to profound hearing loss, however, only 10% of the global need of hearing aids is being met (3% of developing countries' need).

To make all health care services accessible to persons with disabilities and reduce unacceptable health disparities, WHO is supporting the member states to:

- Remove physical barriers to health facilities, information and equipment
- Make health care affordable
- Train all health care workers in disability issues including disability rights
- Invest in specific services such as rehabilitation and assistive technology.

However, several issues and challenges still remain for effective rehabilitation programs to be introduced especially in developing countries. There are large gaps in the provision of rehabilitation services and assistive devices. There is an urgent need for more investment in rehabilitation services.

The World Health Organization has fully participated in the development of the Incheon Strategy. Although health does not have a specific goal, all the 10 goals have some elements of health incorporated in them. It will be impossible to achieve any of the goals without focussing on health issues too.

To implement the Convention and Incheon Strategy, WHO has developed a new Global Action Plan which covers health, rehabilitation, disability data, community-based rehabilitation and assistive technology. This plan is expected to be endorsed at the 67th World Health Assembly in Geneva in May 2014. We expect this new plan of action will open new opportunities for persons with disabilities and assist them to realize their right.

In conclusion, I wish you all a successful workshop and look forward to working with you to Make the Right Real for Persons with Disabilities.

Thank you.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын нэрийн өмнөөс ”Эрхийг бодит болгоё” үндэсний хуралд оролцож байгаадаа баяртай байна.

Сүүлийн хэдэн жил, НҮБ-ын Ерөнхий Ассамблей болон ДЭМБ-ын дээд чуулган, хурлуудаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг бодит болгоё асуудлаар хэд хэдэн удаа хэлэлцэж байсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц хэрэгжиж эхэлснээс хойш Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага Дэлхийн Банктай хамтран Хөгжлийн Бэрхшээлийн талаарх Дэлхийн тайланг 2011 онд гаргасан болно.

Товч дүгнэн толилуулахад, Дэлхийн тайланг дараахь байдлаар харж болно:

- Дэлхий дээр 7 хүний нэг нь буюу 1 тэрбумаас дээш хүн ам хөгжлийн бэрхшээлтэй бөгөөд энэ тоо насжилт, халдварт бус өвчин, замын осол гэмтэл, гамшиг зэргээс хамаарч ихсэх хандлагатай байна.
 - Эдгээр насанд хүрэгсэдийн 15% буюу 110-190 сая хүн ам үйл ажиллагааны хүндэрсэн бэрхшээлтэй байна.
 - Нийт хүн амтай хурьцуулахад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэндийн байдал илүү муу байдаг
 - Боловсролын түвшин доогуур
 - Эдийн засгийн оролцоо бага
 - Ядуурал өндөр түвшин
 - Хамаарал өндөр, оролцоо сул
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусад хүүмүүстэй адил тусламж үйлчилгээ шаардлагатай боловч:
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг байгууламж, ур чадварын хувьд 2 дахин сэтгэл ханамж муу байдаг
 - Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахад 3 дахин татгалзсан хариу авдаг
 - Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахад 4 дахин илүү хүнд сурталд өртдөг
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хоёр хүний нэг нь эрүүл мэндийн үйлчилгээний зардлыг гаргаж чаддаггүй; эрүүл мэндийн хэт өндөр зардалд 50% дахин илүү өртөх магадлалтай. Энэ хувиасаа төлж байгаа зардал нь гэр бүлийг нь ядууралд хүргэх нь олонтаа тохиолддог.
 - Хөгжлийн бэрхшээлтэй 70 сая хүн амд тэргэнцэр шаардлагатай боловч зөвхөн 5-15% н тэргэнцэр авч чадаж байна, мөн 360 сая хүн ам дундаас хүнд зэргийн сонсголын бэрхшээлтэй бөгөөд зөвхөн 10% нь хэрэгцээгээ хангаж туслах хэрэгсэл авч чадаж байгаа (энэ нь хөгжиж буй орнуудын хувьд зөвхөн 3% гэсэн үг)

Эрүүл мэндийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрх тэгш хүргэхийн тулд ДЭМБ-с Гишүүн Орнуудад дараахь зөвлөмжүүдийг санал болгож байна:

- Эрүүл мэндийн төв, эмнэлгүүд байгууламжийн барилга, тоног төхөөрөмжийн саад, мэдээллийн хомс байдлыг арилгаж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ээлтэй орчин бий болгох
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй болгох
- Эрүүл мэндийн бүх ажилтнуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгарч буй бэрхшээл, хүний эрхийн асуудлаар сургалт явуулах
- Сэргээн засалт болон туслах төхөөрөмжийн чиглэлээр хөрөнгө оруулалтыг хийх.

Гэхдээ, хөгжиж буй орнуудад сэргээн засах хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хэд хэдэн бэрхшээл байсаар байна. Сэргээн засалт болон туслах төхөөрөмжийн чиглэлээр үйлчилгээ явуулахад хийх нэвтрүүлэх ажил их байгаа тул хөрөнгө оруулалтыг цаг алдалгүй энэ салбарт хийх шаардлагатай.

Инчоны Стратегийг боловсруулахад Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын оролцоо байсан болно. Хэдийгээр эрүүл мэндийн асуудал биеэ даасан зорилго болж ороогүй боловч, энэхүү Стратегийн 10 зорилгод эрүүл мэндтэй холбоотой асуудлууд тусгагдсан болно. Учир нь эрүүл мэндийн асуудлуудыг шийдэхгүйгээр тавьсан зорилгуудад хүрэхэд боломжгүй юм.

Конвенц болон Инчоны Стратегийг хэрэгжүүлэхийн тулд Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас Дэлхийн Үйл Ажиллагааны Төлөвлөгөөг боловсруулсан бөгөөд энэхүү төлөвлөгөөнд эрүүл мэнд, сэргээн засалт, хөгжлийн бэрхшээлийн талаарх тоо мэдээ, хамт олонд түшиглэсэн сэргээн засалт, болон туслах төхөөрөмжийн асуудлууд хөндөгдсөн болно. Энэ төлөвлөгөөг 2014 оны 5 сард болон Дэлхийн Эрүүл Мэндийн Дээд Чуулганаар батлах болно. Энэхүү Төлөвлөгөө нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст шинэ боломж нээж өгөх, тэлний эрхийг бодит болгоход их ая холбогдолтой бодлого юм.

Дүгнэж хэлэхэд, энэ үйл ажиллагаанд амжилт хүсэхийн зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх нь бодит болохын төлөө хүсэн хүлээж байгаагаа илэрхийлье.

Баярлалаа.

REMARKS



**Mr. Oyunbaatar Tseden
President, Mongolian National Federation of
Disabled People's Organizations and Promoter
for the Asian and Pacific Decade of Persons
with Disabilities, 2013-2022**

Dear Mr. President of Mongolia, Speaker of Great Khural, and Prime Minister!
Dear Parliament Members, Minister of Population Development and Social Welfare!
And Dear Guests and Representatives!

First of all, on behalf of all the persons with disabilities, I would like to express my gratitude to the Government of Mongolia, particularly the Ministry of Population Development and Social Welfare for organizing this ceremony to adopt the Incheon Strategy to "Make the Right Real" for persons with disabilities in the Asia and Pacific region and also the national and international representatives for participating in this ceremony.

Incheon Strategy was adopted by governments at the high-level intergovernmental meeting on the Asian and Pacific Decade of Disabled Persons 2013-2022, organized by ESCAP in Incheon, Republic of Korea from 29 October to 2 November 2012.

We hope and believe that the implementation of this strategy will enable us to track progress towards improving the quality of life, and the fulfillment of the rights of the region's 650 million disabled persons, including Mongolian disabled persons to participate in social life equally as the others.

The reasons we believe are:

1. The development of the Incheon Strategy benefited from the contributions of governments, civil society organizations, organizations of and for persons with disabilities, and other key stakeholders. It was developed from feedback and insights obtained through regional consultations based on the Convention on the Rights of Persons with Disabilities, Biwako Millennium Framework for Action and Biwako Plus Five towards an Inclusive, Barrier-free and Rights-based Society for Persons with Disabilities in Asia and the Pacific.
2. The strategy is more feasible to compare with the previous strategies and programs as its 10 goals, 27 targets, and 62 indicators for tracking progress are more detailed.

But the most important thing is the governments, civil society organizations, organizations of and for persons with disabilities have the ambition to fulfill this strategy.

I understand the reason for organizing this ceremony to adopt the Incheon Strategy is that the Government of Mongolia would like to show its promise to persons with disabilities in all parts of Mongolia, the governments of Asia and Pacific region, and its international partner organizations with the help of all the national and international representatives taking part in the ceremony. This is one of the reasons why we hope and believe. The government of Mongolia has the full potential source to keep this promise.

1. The Great Khural of Mongolia made many amendments related to the rights of persons with disabilities on seven laws in August, 2007; ratified the Convention on the Rights of Persons with Disabilities and its Optional Protocol on December 19, 2008; made several amendments on the "Law on Social Security of Persons with Disabilities", Law on Education, and Law on Welfare in 2012 and 2013; reflected the issues related to persons with disabilities on the state documents and policies; and the government approved an action plan towards the fulfillment of the UN Convention on the Rights of the Persons with Disabilities by its Decree#281 on August 2, 2013.

The above mentioned facts reveal that generally we have the legal environment to fulfill the Incheon Strategy. However, we need to strengthen and ensure its implementation.

2. In 2012, the Ministry of Population Development and Social Welfare created an official department and unofficial consultation board to deal with issues related to persons with disabilities, which gave us opportunities to solve problems within a certain framework and to cooperate and share our experiences.

3. There was a wrong attitude to see persons with disabilities as sick, unskilled people who need care. Now we believe that government, organizations of and for persons with disabilities, and persons with disabilities themselves understand that they had misunderstanding and this wrong attitude disabled the persons with disabilities to be on their own and to enjoy their rights to be the same as others. It is progress. It must be the beginning of the BIG CHANGE.

4. Mongolia is increasing its budget for persons with disabilities year by year. It has a positive effect on the fulfillment of the strategy. However, it is necessary to control the spending of this budget.

Although Mongolia generally has good conditions to implement the Incheon Strategy, there are many things to bear in mind regarding each target of the strategy. Specifically:

1. Reduce Poverty

Most persons with disabilities of Mongolia are living only on social insurance and disability pension. The minimum amount of pension is 103,000 tugriks monthly. Is it enough to buy basic commodities? Obviously, it is impossible as there is a gradual increase in the prices of all products. Therefore, persons with disabilities have a high possibility to be impoverished. There is no detailed study on this issue. However, there is an urgent need to identify the starting point after estimating how many percent of persons with disabilities have been affected by poverty? What are the causes? In other words, we must carry out a study. In this way, we make our plans to reduce poverty and calculate their results.

One of the best ways to help persons with disabilities and deal with poverty is to support employment. We can increase the employment of persons with disabilities with the help of the Ministry of Labor, its agencies, employers, and persons with disabilities themselves.

Despite excellent policies, employers do not have positive attitudes towards persons with disabilities.

In order to change employers' attitudes, first of all, we need to change the ways we determine the level of capacity loss of persons with disabilities. We should develop new methods to calculate how many percent of the person's disability has been lost in terms of skills to do certain job.

In addition to this, persons with disabilities should be skillful and have enough knowledge, education, and be wholehearted to do a certain job.

It is important to involve persons with disabilities in vocational training centers, create appropriate conditions to study, and to support the teachers to learn methods to work with disabled people.

There is also a need to do a study on persons with disabilities who have studied in vocational training centers.

2. Promote participation in political processes and in decision-making

In 2008, the total number of voters registered for the parliamentary election was 1,542,617. From the total number of registered voters, 1,179,448 voted. The voting percentage was 76.46 per cent.

In this case, as there are 39,265 persons with disabilities who have the right to vote, only 2.54 per cent voted. In a country with a majoritary system, there is almost no chance to be elected on behalf of the others.

Moreover, the level of minimum charge to be elected from parties and the costs spent for the election advertisements play big roles in this failure.

With the intention of giving opportunities to persons with disabilities to represent others in all levels of decision-making processes, there is a need to introduce a proportional election system and put the names of educated and knowledgeable persons with disabilities in the list of election candidates.

In 2013, Braille voting sheets were first introduced and used for the presidential election. It was significant for persons with sight impairment to vote independently.

In the future, there are needs to make budgets cover the costs for voting boxes, conduct trainings on sign language to use during the election to give instruction for persons with hearing impairment, to use Braille voting sheets and to equip the election posts for persons with disabilities.

3. Enhance access to the physical environment, public transportation, knowledge, information and communication

State-owned buildings and constructions, roads, public transportation, schools, apartment buildings, hospitals, workplaces and inside and outside constructions and physical environment must be accessible and we need to remove barriers.

Inaccessibility of such constructions has been causing barriers for the daily lives of persons with disabilities and their rights have been violated. For instance: There are 1,174 buses of 25 big enterprises, and 872 additional routed buses of 24 small and medium enterprises serving in the city. However, none of them is equipped with special means for persons with disabilities causing difficulties to get services. There are many more barriers like this.

Information and communication and emergency services shall be made accessible as well. In order to remove barriers and improve the accessibility, we need to have human resources to support and mediate as guides, readers, and sign language interpreters.

In addition to this, access to new information and communication technologies, more specifically the internet, shall be enhanced.

4. Strengthen social protection

It is important to change the methods to determine disabilities and develop new ways to estimate the capacity loss of persons with disabilities accurately. It is inevitably significant to provide persons with disabilities services like personal assistants and consultants.

Furthermore, there are needs to develop and approve national rehabilitation programs and reconsider health insurance for persons with disabilities.

5. Expand early intervention and education of children with disabilities

According to unofficial sources of information, it is estimated that there are 32,516 children with disabilities in Mongolia. It is good news to have a commission established to determine the disabilities of children. We believe that the establishment of this commission will play an important role and enable us to detect disabilities of children early and build up and disseminate information on the rights of children with disabilities.

There is a necessity to develop a system to support the families with disabled children. It is essential to have supportive devices, appropriate curriculum, and lesson materials for the schoolchildren with intellectual disability, different types of disabilities, hearing and sight impairment, and autism.

6. Ensure gender equality and women's empowerment

Girls and women with disabilities become victims of various forms of discrimination and abuse. Thus, we should promote access to information on sexual and reproductive health care, general health and related services and active involvement of girls and women with disabilities in development activities.

7. Ensure disability-inclusive disaster risk reduction and management

We should regularly involve persons with disabilities in emergency situations and disaster risk reduction activities at all local and regional levels.

8. Improve the reliability and comparability of disability data

Correct and accurate statistics and data on disability provide us with opportunity to develop practical policies to ensure the rights of persons with disabilities and protect them. Accordingly, there should be an agreed concept on the terms “Disability” and “Persons with Disabilities” in Asia and Pacific region. Moreover, we would like to have a meeting where the personnel responsible for statistics and data can get together to form modified methods for information gathering on persons with disabilities organized among the representatives of the countries in Asia and Pacific region.

9. Accelerate the ratification and implementation of the Convention on the Rights of Persons with Disabilities and the harmonization of national legislation with the Convention

Given today's opportunity, I would like to express my gratitude to the Great Khural for ratifying the Convention on the Rights of the Persons with Disabilities and its Optional Protocol on December 19, 2008 and the Government of Mongolia for approving the action plan towards fulfillment of the UN Convention on the Rights of the Persons with Disabilities by its Decree#281 on August 2, 2013.

We hope that all social sectors particularly organizations of and for persons with disabilities will make efforts to fulfill this plan.

10. Advance sub-regional, regional and interregional cooperation

As a result of participation and collaboration of all ministries and agencies of different sectors, the government, governmental organizations at all levels, civil society organizations, especially organizations of and for persons with disabilities and the organizations and groups that support persons with disabilities and their families, research institutes, and private organizations, we believe that we can achieve the Incheon Strategy goals and targets. Therefore, we shall develop a national mechanism with the authority to manage, organize and combine the efforts of above mentioned parties.

We shall expand our collaboration by sharing experience, exchanging information, and providing technical support at the regional level.

Awarded as one of the 7 Promoters of the Asian and Pacific Decade of Persons with Disabilities, 2013-2022 and Incheon Strategy to “Make the Right Real”, I promise that I will do my best to fulfill this strategy.

Let the hopes and dreams of persons with disabilities come true!

Эрхэм хүндэт Монгол Улсын Ерөнхийлөгчөө, Их Хурлын даргаа, Ерөнхий сайдаа
Эрхэм хүндэт Их хурлын гишүүн ХАХНХамгааллын сайдаа
Эрхэм хүндэт зочид төлөөлөгчидөө

Юуны өмнө Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг нь бодитой болгох” Инчеоны стратегийг хүлээн авах ёслолын арга хэмжээг зохион байгуулж байгаа Монгол Улсын Засгийн Газар, ялангуяа ХАХНХЯамны хамт олонд болон энэ арга хэмжээнд оролцож байгаа гадаад, дотоодын төлөөлөгч та бүхэнд нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ өмнөөс баярласнаа илэрхийлж байна.

Инчеоны стратеги нь 2012 оны 10 дугаар сарын 29 –нөөс 11 сарын 2 ны хооронд Солонгосын Инчеон хотод болсон, АНДБЭЗНК-ын бүс нутгийн засгийн газар хоорондын дээд хэмжээний чуулга уулзалтаар баталсан Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 2013-2022 оны 10 жилийн хөтөлбөр юм.

Энэ хөтөлбөр хэрэгжсэнээр Ази болон Номхон далайн бүс нутагт амьдарч байгаа 650 сая хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, түүний дотор Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдралын нөхцөл улам бүр сайжирч, хөгжлийн бэрхшээлтэй иргэд бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцох бодит бололцоо нэмэгдэнэ гэж найдаж байна, бас итгэж байна.

Найдаж бас итгэхийн учир нь:

1. Инчеоны стратегийг Засгийн газрууд болон иргэний нийгмийн төлөөлөлтэй зөвлөлдсөний үндсэн дээр Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц болон Бивако-гийн Мянганы Хүрээн дэх Үйл Ажиллагаа, мөн Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангасан, саадгүй, эрхэд суурилсан нийгмийг чиг болгосон Бивако-гийн нэмэлт 5 зарчим дээр тулгуурлаж боловсруулсан.

2. Энэ хөтөлбөр өмнөх хөтөлбөрүүдийг бодвол дэвшүүлсэн 10 зорилго, 27 зорилт тус бүрийн хэрэгжилтийг хэмжих 62 шалгуур үзүүлэлтүүдийг нарийвчлан зааж өгсөнөөрөө хэрэгжих бүрэн үндэстэй болсон явдал юм.

Гагцхүү Засгийн Газрууд болон иргэний нийгмийн байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх чин эрмэлзлэлтэй байх ёстой.

Монгол Улсын Засгийн Газар Инчеоны стратегийн баримт бичгийг хүлээн авах ёслолын арга хэмжээг зохион байгуулж байгаа нь гадаад дотоодын төлөөлөгчид та бүхнээр дамжуулан Монгол орны өнцөг булан бүрт суугаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд, Ази Номхон далайн бүсийн орнуудын хөгжлийн бэрхшээлтэй иргэд, Ази болон Номхон далайн бүсийн засгийн газрууд болон Олон Улсын Хамтын Ажиллагааны байгууллагуудын өмнө Инчеоны стратегийг хэрэгжүүлэх чин хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн илэрхийлэл, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ эрхийг бодитоор хангахаа амласан амлалт гэж үзэж байна. Итгэж найдахын бас нэг учир нь энэ.

Монгол Улсын Засгийн Газарт энэхүү амлалтаа биелүүлэх бүрэн боломж бий.

1. Монгол Улсын Их Хурал 2007 оны 08 дугаар сард салбарын 7 хуулинд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангахтай холбоотой асуудлаар олон нэмэлт өөрчлөлт оруулсан, 2008 оны 12 дугаар сарын 19 ны өдөр “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг, нэмэлт протоколын хамт” соёрхон баталсан, 2012, 2013 онд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай”, Боловсролын тухай, Халамжийн тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулсан, Төрөөс хүн амын талаар баримтлах бодлогын баримт бичигт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг тусгасан, Шинэчлэлийн Засгийн Газар 2013 оны 08 сарын 02 нд 281-р тогтоолоороо Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө баталсан.

Энэ нь Инчеоны стратегийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин ерөнхийдөө байна гэсэн үг. Чухамдаа эдгээрийг улам боловсронгуй болгож, хэрэгжилтийг хангах нь чухал.

2. 2012 онд ХАХНХЯаманд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан орон тооны хэлтэс, орон тооны бус бодлогын зөвлөл байгуулагдсан нь тодорхой хүрээнд асуудлыг зохицуулах боломжийг олгож, хамтын ажиллагаанд томоохон туршлага болох зүйл юм.

3. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өвчтэй ямар ч чадваргүй хүмүүс, тэднийг зөвхөн халамжлах ёстой гэсэн буруу ойлголт, хандлага нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өөрийнхөө амьдралд эзэн байх, бусадтай адил тэгшээр эрхээ эдлэх боломжийг нь хааж байдаг гэдгийг Засгийн газар ч, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд ч, хөгжлийн бэрхшээлтэй иргэд ч аль аль нь ойлгож эхэлсэн гэж бодож байна. Энэ бол сайн зүйл. Өөрчлөлтийн эхлэл байх ёстой.

4. Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зарцуулдаг төсвөө жил бүр нэмэгдүүлж байгаа. Энэ нь уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд таатай нөлөө үзүүлнэ. Гагцхүү энэ төсвийн өгөөжийг сайжруулахад анхаарах шаардлагатай байна.

Монгол Улсад уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх угтвар нөхцөл бий болсон хэдий ч цаашид Инчеоны стратегийн зорилт тус бүрээр хийх ажлууд их байна. Тухайлбал:

1. Ядуурлыг бууруулах

Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ихэнх нь нийгмийн даатгалын буюу халамжийн тэтгэврээр л амьдарч байна. Халамжийн тэтгэврийн сарын доод хэмжээ 103 мянган төгрөг. Энэ мөнгө хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэглээний сагсыг дүүргэж чадах уу гэвэл юмны үнэ өсч байгаа өнөө үед яагаад ч чадахгүй нь ойлгомжтой. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй иргэд ядууралд өртөх хамгийн өндөр магадлалтай хүмүүс. Одоогоор нарийн судалгаа алга байна. Ямартаа ч энэ хөтөлбөр хэрэгжихийн өмнө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэдэн хувь нь ядууралд өртсөн, ядуурал юунаас үүдэлтэй гэх мэт ядуурлын цар хүрээ, шалтгааныг тогтоож, гарааны нөхцлөө тодорхойлох ёстой. Өөрөөр хэлбэл судалгаа хийх ёстой. Ингэж байж л ядуурлыг бууруулах ажлаа төлөвлөх, үр дүнг тооцох бололцоо бүрдэнэ.

Ядуурлыг даван туулах хамгийн сайн арга замуудын нэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах явдал юм. Хөдөлмөрийн яам түүний харьяа байгууллага, ажил олгогч, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоотойгоор л хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж чадна. Сайн бодлого байхаас гадна ажил олгогч хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар сайн ойлголт хандлагатай байх ёстой. Ажил олгогчийн хандлагыг өөрчлөхийн тулд юуны өмнө хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрийн чадвар

алдалтыг тодорхойлж байгаа одоогийн аргачлалыг өөрчилж, Хүний үйлдлийн хязгаарлалт нь тухайн мэргэжлийн ажлыг хийхэд заавал гүйцэтгэх үйлдлийн хэдэн хувийг эзэлж байгаагаар хөдөлмөрийн чадвар алдалтыг тооцдог аргачлалыг бий болгох ёстой. Үүнээс гадна хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ажиллах чадвартай, тухайн ажлыг хийх хангалттай мэдлэг, боловсролтой, мөн ажиллах хүсэлтэй байх ёстой. Мэргэжлээ сайн эзэмшсэн хүн л ажлын байраа хадгалан үлдэх боломжтой учраас Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцуулах орчин нөхцлийг бий болгох, тухайн сургуулийн багш нарыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажиллах арга барилд сургах ажлыг хийх шаардлагатай байна. Мэргэжлийн сургуульд хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгаа хийх хэрэгтэй.

2. Улс төрийн болон шийдвэр гаргах үйл явц дахь оролцоог хөхиүлэн дэмжих УИХ-ын 2008 оны сонгуулиар сонгогчдын нэрсийн жагсаалтанд 1,542,617 сонгогч бүртгэгдсэнээс 1,179,448 сонгогч саналаа өгсөн байна. Нийт сонгогчдын 76,46 хувь нь саналаа өгчээ. \2008 оны сонгуулийн нэгдсэн дүн\ Тэгвэл сонгуулийн насны санал өгөх эрхтэй хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэд 39265 байгаа нь нийт сонгогчдын 2,54 хувь болж байна. Энэ нь можаритари системийн үед хөгжлийн бэрхшээлтэй иргэд бусдыгаа төлөөлж сонгогдох боломж бараг байхгүй гэсэн үг. Үүнд намуудын тавьдаг мөнгөний босго, сонгуулийн сурталчилгаанд зарцуулдаг зардал ч нөлөөлдөг. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд бусдыгаа төлөөлж бүх шатны хуралд сонгогдох боломж олгохын тулд сонгуулийн пропозианаль системийг нэвтрүүлэх, нэрсийн жашсаалтанд боловсрол, мэдлэгтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг оруулах асуудлыг зохицуулах шаардлагатай.

2013 оны ерөнхийлөгчийн сонгуулиар анх удаа харааны бэрхшээлтэй хүмүүсийн саналыг брайл шаблон хэрэглэж авсан нь саналаа хараат бус өгөхөд чухал ач холбогдолтой зүйл болсон. Цаашид брайл шаблон хэрэглэх, санал өгөх байрыг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд саадгүйгээр тохижуулах, сонголын бэрхшээлтэй иргэнд сонгуулийн хууль тогтоомж, сонгууль өгөх журмыг дохиогоор тайлбарлах сургалт зохион байгуулах, одой хүмүүст зориулсан саналын хайрцаг хийх зэрэг зардлыг шийдвэрлэж хэрэгжүүлэх шаардлагатай.

3. Хүрээлэн буй орчин, нийтийн тээвэр, мэдлэг, мэдээлэл болон харилцаа холбооны хүртээмжийг сайжруулах

Төрийн захиргааны барилга байшин, зам, нийтийн тээвэр болон сургууль, орон сууцны байр, эмнэлгийн газар, ажлын байр зэрэг бүх төрлийн доторхи болон гаднах байгууламжийн хүртээмжгүй байдал, саадыг арилгах шаардлагатай байна. Эдгээр нь хүртээмжгүйгээс болоод хөгжлийн бэрхшээлтэй иргэд өдөр тутмынхаа амьдралд түмэн бэрхшээлтэй учирч, эрх нь зөрчигдсөн хэвээрээ байна. Жишээ нь: Нийслэлд нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа том оврын 25 аж ахуйн нэгж, байгууллагын 1174 автобус, туслах чиглэл болон буухиа чиглэлд бага оврын 24 аж ахуйн нэгжийн 872 автобуснуудад суга таяг,тэргэнцэр зэрэг нэмэлт хэрэгсэлтэй хүн орох боломжгүй, хараагүй дүлий хүнд зориулсан үйлчилгээ байдаггүйгээс нийгмийн үйлчилгээнд хамрагдахад бэрхшээл учирдаг. Энэ мэт олон саад байна.

Мэдээлэл харилцаа холбооны болон түргэн тусламжийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд саадгүй хүртээмжтэй болгох шаардлагатай байна.

Хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс хүний туслалцаа, зуучлалын хэлбэрүүд, тухайлбал хөтөч, уншигч, дохионы хэлний мэргэжлийн орчуулагчийг бий болгох нь зүйтэй. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс мэдээлэл, харилцаа холбооны шинэ технологи, систем, үүний дотор интернетийг ашиглах боломжийг нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

4. Нийгмийн хамгааллыг бэхжүүлэх

Хүний хөгжлийн бэрхшээлтэй байдлыг тодорхойлж байгаа одоогийн аргачлалыг өөрчилж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн алдагдсан чадварыг оновчтой тогтоодог шинэ аргачлалыг бий болгох шаардлагатай.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан хувийн туслах болон зөвлөлгөө өгөх зэрэг үйлчилгээнүүдийг бий болгох зайлшгүй шаардлагатай. Үндэсний нөхөн сэргээх хөтөлбөрийг боловсруулж батлуулах, мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан эрүүл мэндийн даатгалыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

5. Хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн хоцрогдолтой хүүхдүүд болон тэдний гэр бүлийг дэмжих тогтолцоо болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролыг өргөжүүлэх

Албан бус мэдээгээр Монголд 32516 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаа гэсэн тоо бий. Саяхан Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн тогтоодог комисс байгуулагдсанд баярлаж байна. Энэ комисс хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт тогтоож, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрхийн талаарх мэдээллийг боловсронгуй болгоход чухал үүрэг гүйцэтгэнэ гэж найдаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлд тусламж дэмжлэг үзүүлдэг тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

Оюуны бэрхшээлтэй, хөгжлийн бэрхшээлтэй, сонсгол, харааны бэрхшээлтэй, аутизмтай болон бусад хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад зориулсан туслах төхөөрөмж, тохирох сургалтын хөтөлбөр, зохих сургалтын материалыг бий болгох шаардлагатай.

6. Жендэрийн эрх тэгш байдал болон эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх явдлыг хангах

Хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүд нь янз бүрийн ялгаварлан гадуурхалт болон хүчирхийлэлд өртдөг. Иймээс Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, ерөнхий эрүүл мэндийн болон холбогдох үйлчилгээний талаарх мэдээлэл нь хүртээмжтэй болгох, Хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүдийг хөгжлийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцуулах шаардлагатай байна.

7. Гамшгийн эрсдлийг бууруулах үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлийн оролцоог хангах

Орон нутгийн болон дүүргийн хэмжээнд явагдаж байгаа онцгой байдал болон гамшгийн эрсдлийг бууруулах арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тогтмол оролцуулах хэрэгтэй байна.

8. Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдээллийн сангийн үнэн бодит байдал болон харьцуулсан тоо баримтыг сайжруулах

Хөгжлийн бэрхшээлийн талаарх статистикийн тоо мэдээ үнэн зөв байх нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах, хамгаалах талаар нилээд ул үндэстэй бодлого боловсруулах боломжийг олгодог. Иймээс “Хөгжлийн бэрхшээл” болон “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс” гэсэн тодорхойлолтын талаар Ази-Номхон Далайн бүс нутагт нэгдсэн ойлголттой болох, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар мэдээлэл цуглуулах нэгдсэн аргачлал боловсруулахад чиглэгдсэн Ази Номхон далайн бүсийн орнуудын статистикийн газрын ажилтнуудын уулзалтыг Монголд зохион байгуулаасай гэж хүсч байна.

9. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийг соёрхон батлуулах болон хэрэгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, үндэсний хууль тогтоомжийг Конвенцтой нийцүүлэх 2008 оны 12 дугаар сарын 19 ны өдөр “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг, нэмэлт протоколын хамт” соёрхон баталсан Монгол Улсын Их Хурал, 2013 оны 08 сарын 02 ны 281-р тогтоолоороо Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө баталсан Шинэчлэлийн Засгийн Газарт баярласнаа илэрхийлье. Энэ төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийгмийн бүх салбар ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд хүчин чармайлт гаргана гэж найдаж байна.

10. Хамтын ажиллагааг сайжруулах

Олон салбарын яамд, газар агентлагууд болон засгийн газрын бүх шатны байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд тухайлан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага болон тэдгээрийг дэмжих байгууллага, тэдний гэр бүлийг дэмжих баг, судалгааны хүрээлэнгүүд болон хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааны үр дүнд Инчеоны стратегийн зорилго, зорилтод хүрч чадна. Иймээс эдгээрийн хүчийг дайчлах, зохион байгуулах эрх бүхий үндэсний зохицуулах механизмыг бий болгох шаардлагатай байна.

Бүс нутгийн түвшинд туршлага солилцох, мэдээлэл хуваалцах, техникийн туслалцаа үзүүлэх зэргээр хамтын ажиллагааг өргөжүүлэх нь зүйтэй. “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг бодит болгох” Инчеоны стратегийг дэмжигчээр Ази Номхон далайн бүсээс сонгогдсон 7 дэмжигчийн нэгний хувьд энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бүх хүч чадлаа дайчлан ажиллахаа та бүхний өмнө амалж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн итгэл найдвар биелэх болтугай

CLOSING REMARKS



Mr. Baatarjav Dambadondog
United Association of People with Disabilities of
Mongolia, Hero of Labor, State Honored Athlete of
Mongolia, the Champion of Beijing 2008 Paralympic
Games

Your Excellency Speaker,
Distinguished Guests,

We are all aware that the Mongolian government accepted and approved the United Nations Human Rights Convention on the Rights of Persons with Disabilities in 2009.

Today, we are gathered here for the Government adoption of the Incheon strategy “Make the Right Real” for Persons with Disabilities in Asia and Pacific.

For the implementation and execution of the above legal Acts, the New Government for Changes established a National Committee and we persons of disabilities are grateful for the action.

Moreover, Ministries and NGOs for persons with disabilities established a task force to work on the revised draft of the persons with disabilities protection law. The persons with disabilities protection law reflected the international legal acts and documents, and thus for the effective development of persons with disabilities.

As the country progresses, the legal documents for defending the rights persons with disabilities also develops; thus requiring NGOs running activities for persons with disabilities in a timely manner. Moreover, we shall work and study to grow as responsible and mature adults.

I would like to remark that effort is the starting point of the success of all athletes.

Best regards.

Эрхэм хүндэт Монгол Улсын Их Хурлын даргаа !
Эрхэм хүндэт Монгол Улсын Их Хурлын гишүүдээ!
Эрхэм хүндэт Зочид төлөөлөгчид, ноёд хатагтай нараа!

Энэ өдөр та бид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төлөө 2009 онд Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрхийн тухай Конвенцийг соёрхон баталж хүлээж авсныг мэдэж байгаа.

Энэ удаа бид Ази болон Номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан “Эрхийг бодит болгоё” Инчеоны стратегийг Монгол Улсын Засгийн газар соёрхон хүлээн авах арга хэмжээнд оролцож байна.

Шинэчлэлийн Засгийн газар дээрх эрх зүйн актуудыг хэрэгжүүлэхээр Засгийн газрын дэргэд Үндэсний Зөвлөлдөх хороог байгуулахаар шийдвэрлэснийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд талархан хүлээн авч байгааг хэлэхэд таатай байна.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар салбарын яамдууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Тус хуульд олон улсын эрх зүйн баримт бичгүүдээс тусгаж цаашдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд хөгжиж дэвжих, хөгжлийн нэгэн баялаг бүтээгчид байхаар бид үргэлж хамтран ажиллах болно.

Улс орон хөгжихийн хирээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах эрх зүйн баримт бичгүүдтэй боллоо. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Төрийн бус байгууллагууд хөл нийлж алхах шаардлагатай. Иймээс ч бид дор бүрнээ хичээн хөдөлмөрлөж, сурч боловсорч, алхам бүрдээ хөгжихийн төлөө зүтгэцгээе.

Хичээл зүтгэл их амжилтын гараа байдаг гэдгийг тамирчин хүний хувьд та бүхэнд анхааруулан хэлмээр байна.

Та бүхний амьдралд сайн сайхан, эрүүл энх бүхнийг хүсэн ерөөе.

PROGRAMME

Part 1. Opening Ceremony

